

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 46
1.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/</i>	6 – 7
2.	<i>Олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллага үүсгэн байгуулах тухай конвенц /Засгийн газар 2026.06.12-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/</i>	8 – 13
3.	<i>Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн байдал болон эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.05.23-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/</i>	13 – 46

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
06 дугаар сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 15 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Д.Бум-Очир;
Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Э.Бат-Амгалан, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Энхбаяр;
Тасалсан: Д.Ганбат, Л.Гантөмөр, Г.Очирбат, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллага үүсгэн байгуулах тухай конвенц /Засгийн газар 2026.06.12-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Гадаад

харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа, мөн яамны Хөрш орнуудын газрын захирал Т.Жанабазар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын арбитрын хэлтсийн дарга О.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийг Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Ч.Анар нарын тавьсан асуултад Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын арбитрын хэлтсийн дарга О.Цолмон нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллага үүсгэн байгуулах тухай конвенцыг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 11 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн байдал болон эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.05.23-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын зөвлөх Д.Одхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийг Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Ч.Анар, Ц.Мөнхбат, П.Наранбаяр, С.Эрдэнэболд, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын зөвлөх Д.Одхүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Б.Тулга, П.Наранбаяр, Б.Батбаатар, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн байдал болон эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 53 минут үргэлжилж, 29 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 65.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “ИХ ЗАСАГ” танхим
11 цаг 15 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ, энэ өглөөний мэндийг хүргэе.

Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Ирцийг танилцуулъя.

Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Сүрэнжавын Лүндэг гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирснээр 6 сарын 30-ны өдрийн хуралдааны ирц бүрджээ.

Ингээд энэ өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх гурван асуудал байгаа.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хоёрдугаарт, Олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллага үүсгэн байгуулах тухай конвенц. Засгийн газар 6 сарын 12-ны өдөр ирүүлсэн. Зөвшилцөх асуудал байна.

Гуравдугаарт, Даян дэлхийн ногоон хөгжлийн институцийн эрх зүйн байдал болон эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институц хоорондын хэлэлцээрийн төсөл байна.

Засгийн газар 2025 оны 5 сарын 23-ны өдөр ирүүлсэн. Зөвшилцөх асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.
/алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Ажлын хэсэг байгуулах тухай/

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Өнгөрсөн тав дахь өдрийн Улсын Их Хурлын чуулганаар Төрийн нууцын тухай хуулийн төслийг хэлэлцсэн байгаа.

Манай Байнгын хороонд шилжүүлсэн Төрийн нууцын тухай хуулийн хоёр төсөл байгаа.

Нэг нь, Засгийн газраас өргөн мэдүүлсэн. Нөгөөх нь О.Цогтгэрэл нарын 18 гишүүдийн өргөн мэдүүлсэн байгаа.

Эдгээр хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах саналтай байгаа.

Ажлын хэсгийн ахлагчаар. Ерөнхийд Та бүхэнд тогтоолын төслийг яасан байгаа. Гишүүд, бүрэлдэхүүнийг, ахлагч нарыг Байнгын хорооны хурал дээрээсээ саналыг нь аваад байгуулаад явъя гэсэн саналтай байгаа.

Одоогийн байдлаар ахалж ажиллах хүсэлтээ ирүүлсэн Ч.Анар гишүүн байна. Ажлын хэсгийн гишүүдэд орох асуудлууд нээлттэй байгаа.

Төрийн нууцын тухай хуультай холбоотойгоор ажлын хэсэг байгуулах асуудал байна.

Ингээд тогтоолын төслийг ерөнхий байдлаар Та бүхэнд танилцуулж байна.

Тэгээд гишүүд ажлын хэсэгт гишүүнээр ажиллах асуудал нээлттэй.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Төрийн нууцын тухай хууль байгаа. Засгийн газраас өргөн мэдүүлсэн болон О.Цогтгэрэл гишүүн өргөн барьсан хоёр хуулийг нэгтгээд намрын чуулганаар хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байхаар байгаа.

Ч.Анар гишүүн ахалъя гэсэн саналтай байна. Өөр саналтай гишүүд байж болно.

Ажлын хэсэгт гишүүнээр орох гишүүд байж болно. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нь хэн хэн байгаа байж болохоор байна. Би хэлээдэхье. Ч.Анар гишүүнээр ахлахаар. Тэгвэл Л.Энхнасан гишүүнийг, С.Эрдэнэболд гишүүнийг, Б.Жаргалан гишүүнийг, Д.Энхтүвшин гишүүнийг, тэгээд Ч.Анар гишүүн, дахиад

хоёр гишүүн байна. Б.Тулга гишүүн үү? Б.Тулга гишүүн амжихгүй. Манай өөр хэн байна? М.Бадамсүрэн гишүүн, С.Лүндэг гишүүн.

Тэгвэл гишүүдийг дахиад нэг хэлээдэхье.

Бүрэлдэхүүнд нь ийм бүрэлдэхүүн байх нь. Ч.Анар гишүүн ахлаад, тэгээд М.Бадамсүрэн гишүүн, Н.Батсүмбэрэл гишүүн, Б.Батбаатар гишүүн. Тэгээд Б.Жаргалан, Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд, Л.Энхнасан гишүүд гэсэн бүрэлдэхүүн болж байна уу? Чи тоогоо бичээдэх.

Ийм бүрэлдэхүүнд санал гишүүд өгч байна.

Өөр саналтай үг хэлэх гишүүд байна уу? Асуулт асуух гишүүд. Алга байна. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Тогтоолын төслийг албан ёсоор уншаад танилцуулаадахъя. “Ажлын хэсэг байгуулах тухай” гээд.

Нэгдүгээрт, Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Төрийн нууцын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Тэгээд мөн Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын өргөн мэдүүлсэн Төрийн нууцын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай гээд.

Ажлын хэсгийн ахлагчаар Ч.Анар, ажлын хэсгийн гишүүнээр Н.Батсүмбэрэл, Б.Батбаатар, Б.Жаргалан, Л.Энхнасан, Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд, Ч.Анар гэсэн.

Ингээд 7 хүний бүрэлдэхүүнтэй байхаар.

Ингээд манай Байнгын хороонд байгаа бүх намуудын төлөөллүүд хангагдсан байна гэж үзэх нь байна. Тийм ээ.

Ингээд “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалтад бэлтгэгчээ. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 15 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 53.3 хувиар дэмжигдлээ.

Ингээд “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа орцгооё.

**Хоёр.Олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллага
үүсгэн байгуулах тухай конвенц**
/Засгийн газар 2026.06.12-ны өдөр ирүүлсэн,
зөвшилцөх/

Хоёр дахь асуудал. Олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллага үүсгэн байгуулах тухай конвенцыг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай. Олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллага үүсгэн байгуулах тухай конвенцын талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн Цэндийн Ц.Сандаг-Очир танилцуулна.

Ажлын хэсгийг оруулж ирье.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллага нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 33 дугаар зүйлд заасан журмын дагуу 2025 онд байгуулсан маргааныг тайван замаар шийдвэрлэх зарчмыг бэхжүүлэхэд чиглэсэн анхны Засгийн газар хоорондын олон улсын байгууллага юм.

Эл байгууллагыг үүсгэн байгуулах тухай конвенцод гарын үсэг зурах асуудлыг Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр ийнхүү танилцуулж байна.

Ийнхүү гарын үсэг зурснаар Монгол Улс эвлэрүүлэн зуучлалын олон улсын бодлого боловсруулах үйл ажиллагаанд оролцох боломжтой болохоос гадна Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арилжаа, бизнес эрхлэгчдийн хоорондын маргааныг шүүхийн бус журмаар шуурхай шийдвэрлэх эрх зүйн тогтолцоог сайжруулна гэсэн зорилтыг хангахад тодорхой үүрэг гүйцэтгэх юм.

Манай улс дээрх байгууллагын гишүүн болсноор конвенцын оролцогч улсуудтай худалдаа, хөрөнгө оруулалт болон бусад салбарын маргааныг хялбаршуулсан аргаар эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэх боломж бүрдэж олон улсын маргааныг шүүх, арбитраас гадна эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх нэмэлт механизмыг бүрдүүлнэ.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай хөшүүрэг бий болгох, маргааныг тайван замаар шийдвэрлэх зарчмаар тууштай дэмжигч улс болохоо нотлох, эвлэрүүлэн зуучлах олон улсын туршлагыг судлах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, дотоодын хууль, зохицуулалтыг сайжруулахад туршлага хуримтлуулах зэрэг олон давуу талыг харгалзаж ийнхүү конвенцод гарын үсэг

зурахаар танилцуулж буй тул асуудлыг хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргаж өгнө үү. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ц.Сандаг-Очир сайдад баярлалаа.

Олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллага үүсгэн байгуулах тухай конвенцын төсөлтэй холбогдуулаад оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Гадаад харилцааны яамны Гэрээ эрх зүйн газрын дарга Ж.Соёлмаа байна.

Тус яамны Хөрш орнуудын газрын захирал Т.Жанабазар захирал байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны олон улсын Арбитрын хэлтсийн дарга О.Цолмон дарга байна. Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшинийг дуудаарай. Зарлагын хяналтын дэд хороон дээр байгаа юм байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Д.Энхтүвшин гишүүнээр тасалъя. Д.Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Энэ конвенц Хятадын санаачилгаар байгуулагдаж байгаа. Хонконг төвтэй ийм конвенц байгаа.

Тэгээд 30 гаруй улс гарын үсэг зурснаас яг соёрхон баталсан 8 улс байгаа.

Тэгээд ер нь ихэвчлэн хөгжиж байгаа орнууд буюу Америк тэргүүтэй барууны орнууд энэ конвенцод ороогүй байгаа. Нөгөө талд нь Сингапурын яг үүнтэй адилхан маргаан зуучлах конвенц байгаа. Энэ конвенц болон Сингапур хоёрын ялгаа нь эвлэрүүлэн зуучлалын тэр тохиролцоогоо албадан биелүүлэх, гүйцэтгүүлэх боломжийг Сингапурын конвенц нь олгодог. Байнгын бүтэцтэй биш.

Тэгэхээр Хятад энэ Сингапурын конвенцод орохоор гарын үсэг зурсан боловч нэгдээгүй байж байгаа юм.

Тэгээд Хятад Улс төвтэй болохоор яах вэ, Хятадтай холбоотой хөрөнгө оруулагчтай холбоотой маргаанууд нэг талаараа амар хялбар болж магадгүй байх. Нөгөө талаараа нэг талын нөлөөлөл ч юм уу, тэр бүтцийг нь Хятадын хувьд хэдийгээр түүхэн уламжлалтай боловч яг энэ эвлэрүүлэн зуучлалын бүтэц нь яг олон улсын түвшинд сайн хөгжөөгүй гэж ярьдаг юм билээ.

Уг нь цогцоороо бид энэ конвенцод нь ороод, тэгээд Сингапурт нь бас Монгол Улс энд ороогүй байж байгаа. Орчихвол эвлэрүүлэн зуучлан тохирсон зүйлээ албадан гүйцэтгүүлэх энэ бололцоо боломжуудыг нь хангаад өгвөл арбитрын өмнө бас нэг ийм бололцоо юм уу гэж бодоод байгаа юм. Гэхдээ яах вэ ингэвэл Сингапуртай нь нэгдээд орчихвол цогц юм шиг харагдаж байгаа. Гэтэл Хятад маань тэнд орохгүй. Одоогоор оръё гэсэн гарын үсэг зурсан ч гэсэн соёрхон батлах ийм төлөвлөгөөгүй байгаад байна.

Тэгэхээр энэ уялдаанууд нь Хятадтай холбоотой хөрөнгө оруулагч болон одоо манайд хөрөнгө оруулалт хийсэн. Одоо жишээ нь газрын тосны хөрөнгө оруулагч нар байна. Төрийн өмчит компаниуд. Үүнтэй холбоотой маргаанууд жишээлбэл яг энэ олон улсын гэрээнүүд дээрээ бид эхлээд эвлэрүүлэн зуучлах гэдэг асуудлаа оруулаад. Арбитр гэхээсээ өмнө ингээд явбал уг нь зүгээр байгаа юм. Тэгэхдээ явъя гэхээр бас Хятад маань энэ Сингапурын конвенцдоо орчихвол илүү цогц болох юм уу гэсэн ийм бодлого байгаад байгаа юм.

Яах вэ үүнтэй холбоотой асуулт гэхээр энэ Сингапурын конвенц манайх ер нь ямар бодолтой байгаа вэ? Орох бодол санаа байгаа юу? Өөр энэ эвлэрүүлэн зуучлалтай холбоотой асуудлууд дээр ямархуу бодлого барих вэ? Олон улсын конвенцуудад нэгдэх талаар.

Дээр нь Хятадад төвтэй эвлэрүүлэн зуучлах энэ конвенцод нэгдсэнээрээ бусад барууны ч гэдэг юм уу хөрөнгө оруулагчид энэ эвлэрүүлэн зуучлах энэ бүтцийг ашиглахгүй байх магадлал хэр вэ? Энэ талаар... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс асуултад хариулъя. Индрийн микрофон дээрээс хэн хариулах вэ? Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын арбитрын хэлтсийн дарга О.Цолмон.

О.Цолмон: Байнгын хорооны гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Хууль зүй, дотоод хэргийн яам О.Цолмон.

Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Сая гишүүний хэлсэнчлэн Сингапурын конвенц хил дамнасан арилжааны маргааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх нөхцөлтэй байгаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байгаа хэлэлцээр нь олон улсын улс хоорондын улс болон хөрөнгө оруулагч хоорондын болон улс орнуудад байрлаж байгаа хувийн хуулийн этгээд хоорондын маргааныг эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааны хүрээнд дэмжлэг үзүүлэх байгууллагын бүтцийг зохицуулсан ийм конвенцод нэгдэж байгаа.

Хоёр дахь асуултад нь хариулахад Сингапурын конвенцод Хууль зүй, дотоод хэргийн яамнаас нэгдэх чиглэлээр зохих судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хийж байгаа. Намрын чуулганаар өргөн мэдүүлэх болов уу гэсэн хүлээлттэй байгаа.

Өнөөдрийн хэлэлцэж байгаа конвенцод нэгдсэнээр аливаа өөр бусад төрлийн эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулдаг байгууллагын үйл ажиллагааг одоо нөгөө үйлчилгээг авах эрхийг хязгаарласан зохицуулалт өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа конвенцод байхгүй ээ гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ч.Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Д.Энхтүвшин гишүүний асуулттай ерөнхийдөө давхардаж байна.

Бид эхлээд Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэдэх Сингапурын конвенцтой элсчхээд энэ асуудлыг хэлэлцэх ёстой байгаагүй юу? Гадаад хэргийн яамны зүгээр бодлогын зүгээс харахаар.

Одоо бид жишээ нь энэ ижил төстэй. Яах вэ, чиг үүрэг нь жоохон өөр. Тэгэхдээ ижил төстэй энэ хоёр конвенцод нэгдэх гэж байна л даа.

Тэгэхээр илүү Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэдэх конвенцдоо нэгдчихээд, олон улсад байр сууриа тодорхойлчихоод, дараа нь энэ конвенцод нэгдэх ёстой байсан уу гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуудал нь, одоо энэ орж ирж байгаа конвенцын хэлэлцээрийн нөхцөлүүд дээр харахаар манай улсын тодорхой хил хязгаар, нутаг дэвсгэр, үндэсний аюулгүй байдалтай холбогдолтой ус, эрчим хүч, онц чухал дэд бүтэц, батлан хамгаалах, стратегийн салбарын хэлцлүүдийг Засгийн газрын хэлэлцэж байж орж, тогтоолоор орж байж тухайн байгууллагууд нь зуучлалд орох зохицуулалт хийгдсэн юм болов уу гэсэн хоёр асуулт асууя.

Г.Тэмүүлэн: Ч.Анар гишүүний асуултад хариулъя. Гэрээ эрх зүйн газрын дарга Ж.Соёлмаа дарга. Индрийн микрофон.

Ж.Соёлмаа: Сайн байцгаана уу? Гэрээ эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа.

Ч.Анар гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээр асуултын хувьд гэх юм бол яах вэ түрүүний хэлснээр Сингапурын олон улсын эвлэрүүлэн зуучлалын конвенц нь илүү тухайн шийдвэрээ хэрхэн биелүүлэх вэ тал дээр дотоодын зохицуулалтыг нарийвчилж тусгаж өгсөн ийм Нэгдсэн Үндэстний Байгууллагын хэмжээний конвенц байгаа.

Энэ дээр бол Хууль зүй, дотоод хэргийн яам болон манай хоёр судлаад дотоодын хуульдаа шингээх зохицуулалтууд байгаа учраас нарийвчлан судлах шаардлагатай гэж үзэж байгаа.

Энэ олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллагад манайх үүсгэн байгуулах тухай конвенцод нь өнөөдөр Байнгын хороогоор зөвшөөрөх юм бол гарын үсэг зурж байгаа.

Өнөөдөр энэхүү конвенцод 44 улс гарын үсэг зурсан. 10 улс нь зөвхөн соёрхон баталсан байгаа.

Энэхүү байгууллага нь өөрөө 2025 оны 5 сард үүсгэн байгуулах тухай зөвхөн конвенцоо гаргасан. Тэр дагуу эвлэрүүлэн зуучлалын гэрээг яаж

дотоодын хуульдаа шингээх вэ, яаж одоо биелүүлэх вэ гэдэг тэр бүх протокол, тэр зохицуулалтууд нь дахиад гишүүн улсуудын дунд хэлэлцэгдэж, дүрмүүд нь гарах нь дутуу байгаа.

Тэгэхээр бид гарын үсэг зурсны дараа ажиглагч улс болох буюу тухайн тэр хэлэлцүүлэгт нь ажиглагчаар оролцоод санаа бодлоо илэрхийлэх энэ эрх нь нээгдэж байгаа. Тэр дагуу гарын үсэг зураад тэр бүх юмыг судлаад.

Тэгээд тэр яг манай дотоодын хуульд нийцүүлэх асуудлууд нь протокол нь тэр байгууллагынхаа хэмжээнд эцэслэснийхээ дараа бид соёрхон батлах асуудлыг оруулахдаа мөн дотоодын хуульд өөрчлөлт нэмэлт оруулах уу яах вэ гэсэн нарийвчилсан зүйлүүдээ дахин яана.

Мөн хоёрдугаар асуудал дээр хэлэхэд саяын хэлсэн таны улс хоорондын хэлтэй холбоотой зарим маргаантай холбоотой асуудал дээр энэ маргааныг бид нэгдэж орохоороо харгалзахгүй ээ гэсэн **reservation**¹-д орох боломж байгаа.

Тэр бол мөн соёрхон батлах процессынхоо шатад сайн судлаад. Зарим нэг, 3 улс жишээлбэл өнөөдөр соёрхон батлахдаа reservation хийсэн байна. Тийм reservation хийх боломж бол байгаа.

Г.Тэмүүлэн: Болсон уу? Ч.Анар гишүүн.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүд байна уу? Ч.Анар гишүүнээр тасалъя. Ч.Анар гишүүн.

Ч.Анар: Зарчмын хувьд хоёр улсын найрамдалт харилцаа, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гаргасан санаачилгыг дэмжээд энэ хэлэлцээрт нь үүсгэн байгуулахаар орохыг нь дэмжиж байна.

Гэхдээ гадаад талдаа гаргах мессежээ их нарийн бодоод, Сингапурын конвенцтой нэгдсэний дараагаар үүнийг соёрхон батлах бол зүгээр болов уу. Уялдуулах. Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэдэх байгууллага шүү дээ.

Хоёрдугаарт, маш сайн тодорхой хариулт авч чадлаа. Яг тэр соёрхон батлах тохиолдолд хамгаалалтын заалтуудаа заавал оруулж ирэх шаардлагатай. Манай улсын газар зүйн онцлог, хүн ам зүйн бүтэц, хэл соёлын түүхийн хувьд онцлогтой учраас тэр хамгаалалтын заалтуудыг соёрхон батлахын цаана хэлэлцээрийн түвшиндээ сайн тусгахыг хүсэж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ч.Анар гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

¹ Гэрээний тодорхой нэг буюу хэд хэдэн заалтын эрх зүйн үйлчлэлийг өөртөө бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хэрэглэхгүй, эсвэл өөрчлөн хэрэглэхээ нэг талын мэдэгдлээр илэрхийлэх тайлбар мэдэгдэл.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтыг явуулж эхэлье. 8 гишүүн орсон байна. С.Эрдэнэболд гишүүн орсон байна. Б.Тулга гишүүн ороогүй байна. Санал хураалтыг явуулъя.

Олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллага үүсгэн байгуулах тухай конвенцыг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураалтад 15 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Ж.Соёлмаа захирал байж байгаарай. Дараагийн асуудал дээр хамаарна.

Энэ асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр байгаа.

Ингээд Олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллага үүсгэн байгуулах тухай конвенцыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Дараагийн асуудалдаа орцгооё.

Гурав.Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн байдал болон эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.05.23-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Даян дэлхийн ногоон хөгжлийн институцийн эрх зүйн байдал болон эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцэж эхэлье.

Энэ хэлэлцээрийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир танилцуулна.

Ц.Сандаг-Очир сайдыг микрофонд урьж байна.

Ц.Сандаг-Очир: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс 2013 онд Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн гишүүнээр элсэж, 2014 оноос Монгол дахь хөтөлбөрийн газрыг байгуулан хамтын ажиллагаагаа хэрэгжүүлж ирсэн.

Даян дэлхийн ногоон хөгжлийн институт нь 2012 онд байгуулагдсан, 58 гишүүн оронтой, олон улсын Засгийн газар хоорондын байгууллага бөгөөд

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн ажиглагчийн статустай Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хөгжлийн тусламжийн зөвлөлөөс хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага юм.

Тус байгууллага нь хөгжиж буй орнуудын ногоон шилжилтийг дэмжих зорилгоор Парисын хэлэлцээр Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд бодлого, техникийн дэмжлэг үзүүлэх, олон улсын буцалтгүй тусламж, ногоон хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэх чиглэлээр ажиллаж, сэргээгдэх эрчим хүч, тогтвортой хот байгуулалт, ногоон санхүүжилт, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох чиглэлээр төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Тус байгууллага нь нийт 58 улсад гишүүнчлэлтэй бөгөөд Их Британи, Австрали, Өмнөд Солонгос, Дани, Арабын Нэгдсэн Эмират Улс, Норвег зэрэг 6 оронтой хандивлагчийн статустай.

Монгол Улсын хувьд тус байгууллагатай хамтран ажилласан 2014-2015 оны хугацаанд үндэсний болон салбарын бодлого боловсруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, судалгаа техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, олон улсын ногоон санхүүжилт татах чиглэлээр бодит үр дүнд хүрсэн. Тухайлбал, үндэсний тодорхойлсон хувь нэмэр /Nationally Determined Contribution (NDC)/, эрчим хүчний салбарын ногоон хөгжлийн стратеги, Эрчим хүч хэмнэлтийн үндэсний хөтөлбөр, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Хот байгуулалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт зэрэг бодлогын баримт бичгийг боловсруулахад дэмжлэг үзүүлж, эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт, хот байгуулалтын чиглэлээр 20 гаруй суурь судалгаа үнэлгээг гүйцэтгэсэн.

Үүнээс гадна жишиг ногоон цэцэрлэг, Сайншандын нарны дулааны станц, хог хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх, сургууль, цэцэрлэгийн дулаан хангамжийг шинэчлэх зэрэг төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, Монголын ногоон санхүүгийн корпорац байгуулах, Орон сууцын дулаан хангамж, техникийн шинэчлэл, орон нутгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх зэрэг төслүүдэд олон улсын санхүүжилтийг татах суурийг бүрдүүлсэн байдаг.

Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн удирдах зөвлөлөөс 2024 оны 10 дугаар сард гаргасан шийдвэрийн дагуу 2026 оны 12 дугаар сарын 31-нээс эхлэн эрх зүйн байдлын хэлэлцээр байгуулаагүй гишүүн орнуудад хөтөлбөрийн түвшний үйл ажиллагаа явуулахгүй, олон улсын ажилтнуудыг тухайн улсад байршуулахгүй байх бодлого хэрэгжүүлэхээр болсон байна.

Иймд Монгол Улс тус байгууллагатай хамтын ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхийн тулд энэхүү хэлэлцээрийг ойрын хугацаанд байгуулах шаардлага үүсээд байгаа юм.

Энэхүү хэлэлцээр нь Монгол Улсын бүрэн эрхэд нөлөөлөх, эсхүл шинэ байгууллага байгуулах агуулга агуулаагүй бөгөөд зөвхөн Даян дэлхийн ногоон

хөгжлийн институтийн Монгол дахь хөтөлбөрийн газрын эрх зүйн статус, үйл ажиллагааны нөхцөлийг олон улсын нийтлэг жишгийн дагуу зохицуулах зорилготой юм.

1.Энэхүү хэлэлцээр байгуулагдсанаар Монгол Улс болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн хамтын ажиллагаа олон улсын гэрээний баталгаатай болж, тус байгууллагын Монгол дахь үйл ажиллагаа тогтвортой үргэлжлэх нөхцөл бүрдэнэ.

2.Монгол Улсад хэрэгжиж буй олон улс болон цаашид хэрэгжих ногоон хөгжил уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээрх буцалтгүй тусламж, техникийн хамтын ажиллагаа, олон улсын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэнэ.

3.Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн дэмжлэгтэйгээр боловсруулсан хөрөнгө оруулалтын бэлтгэл ажил, техник, эдийн засгийн үндэслэл бүхий төслүүд бодит санхүүжилт татах боломж нэмэгдэж, олон улсын донор байгууллагуудын итгэлцэл бэхэжнэ.

4.Монгол Улс тус байгууллагын Удирдах зөвлөлд саналын эрхтэй гишүүний байр сууриа хадгалж, байгууллагын бодлого, стратегийн шийдвэр гаргах үйл явцад үргэлжлүүлэн оролцох боломжтой хэвээр байна.

5.Монгол Улсын уур амьсгалын санхүүжилт татах институтийн чадавх нэмэгдэж, Парисын хэлэлцээр, Тогтвортой хөгжлийн зорилт, үндэсний ногоон шилжилтийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай олон улсын техникийн болон санхүүгийн дэмжлэгийг үргэлжлүүлэн авах боломж хадгалагдана.

Эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулиа батлан хэрэгжүүлэх шинэ шатад шилжиж байна.

Энэхүү хууль нь зөвхөн эрх зүйн орчныг бүрдүүлэхээс гадна олон улсын хамтын ажиллагаа, ногоон хөрөнгө оруулалт, уур амьсгалын санхүүжилтийн үр дүнтэй татах, институцийн чадавхтай байхыг шаардаж байна.

Өөрөөр хэлбэл Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль батлагдсанаар бид зөвхөн эрх зүйн орчноо бүрдүүлээд зогсохгүй түүнийг хэрэгжүүлэх олон улсын түншлэл, хөрөнгө оруулалт, техникийн дэмжлэгээ хадгалж, улам бэхжүүлэх шаардлагатай болж байна.

Энэ утгаараа Даян дэлхийн ногоон хөгжлийн институттэй тогтоосон хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг баталгаажуулах нь Монгол Улсын ногоон шилжилтийг бодитоор дэмжих, олон улсын санхүүжилт татах боломжийг хадгалах стратегийн ач холбогдолтой гэж үзэж байна.

Иймд энэхүү хэлэлцээрийн төслийг дэмжиж өгөхийг Та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Даян дэлхийн ногоон хөгжлийн институцийн эрх зүйн байдал болон эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институц хоорондын хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад Засгийн газраас Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ц.Сандаг-Очир сайд, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, сайдын зөвлөх Д.Одхүү гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байгаа юм байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. С.Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Д.Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Энэ хэлэлцээр хоёр жилийн өмнө орж ирээд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцчихээд төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн гээд буцсан байна лээ.

Тэгэхээр энэ өмнө нь орж ирснээсээ өөрчлөгдсөн юм байгаа юу? Нэмэлт, өөрчлөлт орсон уу гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт нь, эрх ямба, дархан эрх олгож байгаа олон улсын байгууллагууд ер нь ийм эрх шаарддаг уу?

Тэгээд энэ нь одоо жишээлбэл төсөл дээр 150 сая долларын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа гэж байна л даа.

Тэгэхээр үүнийг ямар ямар төслүүд байдаг юм? Тэгээд олон улсын ижил төстэй эрх ямба, дархан эрхтэй ийм байгууллагууд хэр олон байдаг юм гэдэг хоёрдугаар асуулт байна.

Гуравдугаарт нь, энэ дээр нэг ийм заалт байна лээ. Даян дэлхийн ногоон хөгжлийн институц, энэ байгууллагад ажиллаж байгаа монгол ажилчид нь нийгмийн даатгалд хамаарагдахгүй, татварын хууль үйлчлэхгүй гэсэн ийм агуулга байна лээ л дээ. Нийгмийн хамгааллын талаарх зохицуулалтад хамрагдахгүй, татвар хураамжаас чөлөөлөгдөнө, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомж хамаарахгүй гээд.

Тэгэхээр монгол ажиллагсдын эрх ашиг энэ юунд хамрагдахгүй болохоор яаж шийдэгдэх вэ? Ер нь олон улсын жишгүүд ямар байдаг юм. Энэ талаар мэдээлэл өгөөч? Гурван асуулт.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс хариулъя.

Индрийн микрофон. Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр.

Ш.Батбаяр: Өмнөх Байнгын хороогоор оролцуулсан асуудал дээр тухайн байгууллагын Монгол дахь бүх ажилтнуудад дархан эрх орох олгохоор төсөл байсан.

Энэ удаагийнх дээр зөвхөн тухайн Монгол дахь суурин төлөөлөгчид дархан эрх олгохоор өөрчлөгдсөн байгаа.

Монгол Улсад өнгөрсөн хугацаанд **GGGI** (Global Green Growth Institute) байгууллагаас уур амьсгалын өөрчлөлтийн бодлого үндэсний тодорхойлсон хувь нэмэр, ногоон санхүүжилт, эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүч, аймаг орон нутгийн уур амьсгалын төлөвлөлт, чадавх бэхжүүлэлт гээд чиглэлүүдэд бодлогын баримт бичгүүд боловсруулах, ТЭЗҮ боловсруулах ажлууд дээр хөрөнгө оруулалт хийж байсан байгаа. Татах ажлыг хийж байсан. 150 сая гаруй долларын хөрөнгө оруулалт Монгол Улсад татсан гэж бодож байгаа.

Үүнээс яг тодорхой хэлэх юм бол –

- Монголын ногоон санхүүжүүлэлтийн корпорацыг байгуулахад техникийн дэмжлэг үзүүлсэн байна.
- Эрчим хүчний үр ашгийн төсөл, ногоон барилгын бодлого боловсруулах ажилд техникийн туслалцаа үзүүлсэн байна.
- Улаанбаатар хотын барилгын дулаан шинэчлэлийн төслүүдийн ТЭЗҮ-г боловсруулахад техникийн туслалцаа үзүүлсэн байна.
- 14 аймагт уур амьсгалын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажилд мөн техникийн туслалцаа үзүүлсэн. 470 гаруй төрийн албан хаагчийг сургалт судалгаанд хамруулж байсан байна. Өнгөрсөн хугацаанд.

Мөн одоо хэрэгжиж байгаа томоохон төсөл, хөтөлбөрүүд гэх юм бол сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр 26.6 сая ам.долларын буцалтгүй тусламжаар Сайншанд хотод туршилтын журмаар сэргээгдэх хүчний парк байгуулахаар ажиллаж байгаа.

Хэрвээ энэ туршилтын парк маань амжилттай хэрэгжих юм бол цаашлаад Дундговь, Өвөрхангай, Ховд зэрэг 3 аймагт нэмэлтээр нарны сэргээгдэх хүчний станц байгуулахаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээд явж байгаа. Урьдчилсан байдлаар шорт листэдээ орчихсон байгаа.

Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ижил төстэй яг энэ түвшний байгууллага Монголд дархан эрх ямба эдлээгүй байгаа.

Монгол ажилтнуудын эрх хөндөгдөхгүй. Яагаад гэхээр нөгөө олон улсын байгууллагынхаа шугамаар илүү өндөр нийгмийн даатгалын нийгмийн

халамжийн үйлчилгээ авна гэдгээрээ өөрсдөө тэр юугаа сонгож байгаа гэсэн үг. Статусаа.

Г.Тэмүүлэн: Д.Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтүвшин: Бие бүрэлдэхүүн гэдэг дээр нь Монгол Улсын иргэд энэ дотор түр байхаар заасан байна л даа.

Тэгээд яг энэ тодорхойлолт нь “албан тушаалтнууд” гэсэн нь болохоор Монгол Улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомж хамаарахгүй. Энэ чинь хэд дээр байна. 4.3 дээр нь, 9.6 дээр нь бүх төрлийн татвар хураамжаас чөлөөлөгдөнө. Тэгээд нийгмийн хамгааллын талаарх зохицуулалтад үл хамрагдана гээд заасан байна л даа.

Тэгэхээр яах вэ, энэ заасан юмыг л асуугаад байна. Сая болохоор хамрагдахгүй гээд хэлчихлээ. Энэ гэрээн дээр бол, энэ дээр хуулиуд үйлчлэхгүй ээ л гэсэн тийм заалт байгаад байна. Үүнийг тодруулаад өгөөч.

Г.Тэмүүлэн: Д.Энхтүвшин гишүүний асуултад нэмж хариулъя.

Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр. Индрийн микрофон.

Ш.Батбаяр: Нийгмийн даатгалын асуудлаа саяын хэлсэнчлэн Солонгосын буюу олон улсын байгууллагынхаа журмаар төлье гэдэг дээр байгууллагын нийт ажилтнуудынх нь хүсэлт юм билээ.

Хэлэлцээр дээр бол зөвхөн тухайн байгууллагын тэргүүнийг оруулъя гэдгээр өөрчлөн оруулж ирсэн. Тийм.

Г.Тэмүүлэн: Нэмж Ш.Батбаяр дарга. Индрийн микрофон.

Ш.Батбаяр: Тийм. Албан хаагчид нь дархан эрх эдлэхгүй гэж байгаа юм. Эрх ямба бол эдлэхгүй. Татвар, нийгмийн даатгал гэдэг нь дархан эрх ямба биш шүү дээ. Гишүүн ээ. Тийм ээ.

Г.Тэмүүлэн: Д.Энхтүвшин гишүүний асуултад тодорхой хариулъя.

Төрийн нарийн бичгийн дарга. Индрийн микрофон. Сая яг тодорхой асуулт асууж байна. Татвар болоод нийгмийн даатгал дээр хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх юм уу, эдлэхгүй юм уу? Гэрээнд Та бүхний төсөл дээр орж ирснээр эдлэхээр байна гэдэг асуудлыг ярьж байна. Зөвхөн тэр төлөөлөгч биш бусад албан хаагч нар ингэхээр байна гэдэг асуудлыг яриад байна. Энэ дээр тодорхой хариулт тайлбар өгье.

Байгаль орчны яамнаас өөр газрын дарга нар нь энэ асуудлаа судалсан, мэдэх хүмүүс орж ирсэн хүмүүс байгаа юу? Төрийн нарийн бичгийн даргаас өөр.

Индрийн микрофон.

Ш.Батбаяр: Төлөөлөгч болон албан тушаалтнууд нь татвар, хураамж ногдуулах хураах бүх аливаа үүргээс чөлөөлөгдөнө гэсэн байгаа.

4 дүгээр зүйл дээр. Тийм.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Баярлалаа. Д.Энхтүвшин гишүүн болсон уу? Ч.Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Засгийн газрын танилцуулга дээр энэ “гэрээ баталгаажсанаар даян дэлхийн ногоон хөгжлийн институцийн эрх зүйн байдал, хийж байгаа төсөл, хөтөлбөрүүд баталгаажих болно” гэж танилцуулагдаж байна.

Энэ чинь угаасаа баталгаажаад, хэвийн үйл ажиллагаа, 150 сая долларын хөрөнгө оруулалт хийгдээд явж байгаа хэлцээр юм байна гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ дээр зүгээр тухайн төлөөлөгчийн газрын дипломат статусын асуудал ярьж байгаа болохоос энэ гэрээнүүд нь хүчин төгөлдөр болно, болохгүй гэсэн асуудал яригдаагүй биз дээ? Тийм ээ? Энэ дээр яг тодорхой хариулж өгөхгүй бол зарим гишүүд маань үүнийг баталгаажихаар энэ төслийн хөрөнгө оруулалтууд явах юм байна гэж ойлгоод байгаа.

▷ **Нэгдүгээрт,** гэрээ баталгаажсан, баталгаажаагүй хөрөнгө оруулалтууд явах юм байна гэж ойлгож байна.

▷ **Хоёрдугаарт,** энэ газар хэдэн улсад ийм дипломат статус, immunity_[дархан эрх, эрх ямба] авсан бэ?

▷ **Гуравдугаарт,** Монголд дэд бүтэц, нийгэм, эдийн засгийн олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг, дэмжлэг үзүүлдэг маш олон байгууллага байгаа.

ЖАЙКА, КОЙКА, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, хуучин Швейцарын хөгжлийн агентлаг.

Тэд бас ийм дипломат статустай юу? Дипломат статусгүй.

Дахиад саяын яригдаж байгаа хөндөгдөж байгаа заалтаар маш олон, одоо бараг хэдэн мянган дипломат статустай албан хаагчид олон улсын байгууллагынх нь энэ дипломат статус, имунити нь аягүй өндөр байгаа шүү дээ. Тэгж орж ирэх нь.

Тэгэхээр бид дараад нь Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоороо дараа нь ЖАЙКА орж ирэх юм байна, КОЙКА орж ирэх юм байна. Зөв үү?

Тэгэхээр би одоо байгаа энэ дипломат статусыг хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр дээр үйл ажиллагаагаа явуулахад нь саад болж байна гэж үзэхгүй байна л даа.

Г.Тэмүүлэн: Ц.Сандаг-Очир сайд хариулаад, нэмэлтээр ажлын хэсгээс хариулаад явъя.

Ц.Сандаг-Очир сайд.

Ц.Сандаг-Очир: Даян дэлхийн ногоон хөгжлийн институт нь дэлхийн нийт 70 оронд үйл ажиллагаагаа явуулж байна. Түүнээс 58 орон нь гишүүнээр элссэн байна.

Эдгээр 58 орноос 47 нь Засгийн газрын хэлэлцээрээ баталсан байна.

Түрүүн миний танилцуулгад энэ оны 11 сараас эхлээд хэлэлцээрээр батлагдаагүй улсууддаа үйл ажиллагаагаа явуулахаа зогсоох шийдвэр гараад байж байгаа юм байна гэдгийг би түрүүн танилцуулсан.

Нөгөө талаар өмнө нь одоо энэ чинь хэд хэдэн удаа орж ирж буцсан.

Ер нь 2016, 2018 оноос авхуулаад энэ асуудлаа ярилцаж яваад бараг 9 дэх жилдээ асуудал ярьж яваа. Дархан эрх, ямбын асуудлаа.

Тэгээд буцаад байсан шалтгаанууд нь бол энэ төлөөлөгчийн газрын бүх нийт ажилтан, албан хаагчдаа дархан эрх, ямбын асуудал яриад байсан. Одоо бид буцаагаад зөвхөн төлөөлөгчийн газрын удирдах албан тушаалд нь, даргад нь дархан эрх, ямбыг нь олгоё. Төлөөлөгчийн газрын бусад ажилтнуудад одоо энэ дархан эрх, ямбыг нь олгохоо больё гэдэг ийм байдлаар өнөөдрийн энэ Байнгын хорооны хуралд оруулж ирж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд бусад асуудлуудад Төрийн нарийн хариулчих.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг. Индрийн микрофон.

Ж.Соёлмаа: Ч.Анар гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө Нэгдсэн Үндэстний Байгууллагын бус статустай олон улсын байгууллагын хувьд гэх юм бол бид дипломат дархан эрх, ямба, татварын болон бусад бүх хөнгөлөлт чөлөөлөлт буюу дотоодын хуулиас давамгайлсан эрх, ямба олгох гэж байгаа бол тусгайлсан **Host Country Agreement** [хүлээн авагч улсын гэрээ] тухайн байгууллагатайгаа байгуулдаг ийм жишиг байгаа.

Тухайн Нэгдсэн Үндэстний Байгууллагын бус байгууллагад host country agreement байгуулах зөвшөөрлийг ямар нөхцөлөөр олгодог вэ гэхээр тухайн байгууллага нь хэр хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа, цар хүрээ нь хэр байна гэдэг бүх зүйлийг хариуцсан

байгууллага нь үнэлэлт дүгнэлт хийгээд тэгээд тухайн байгууллагатай Засгийн газар host country agreement байгуулъя. Тэр agreement-аараа дархан эрх, ямбыг тухайн байгууллагадаа өгье гэдэг ийм зөвшилцөлд хүрдэг.

Host country бүх agreement-уудыг шүүж үзээд тодорхой нарийвчилсан тоо гаргаж өгч болно. Одоо байгаа мэдээллээр Олон Улсын Валютын Сан, Азийн хөгжлийн банк, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк, тэгээд хүмүүнлэгийн байгууллагуудаас гэх юм бол олон улсын Улаан Загалмайн нийгэмлэг, Улаан хавирган сар зэрэг байгууллагуудтай host country agreement байгуулаад тэдгээрт эрхээ буулгаж байгаа.

Г.Тэмүүлэн: Ч.Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Ц.Сандаг-Очир сайдын тайлбараас ойлгож байна.

Гол нь Гадаад хэргийн яамнаас асуугаад байгаа нь одоо энэ институцээс илүү том нийгмийн болон эдийн засгийн хөрөнгө оруулалт хамтын ажиллагаа хийсэн байгууллагууд зөндөө байгаа. Тийм ээ. Хамгийн эртнийх нь ЖАЙКА байна, КОЙКА байна. Эд нар барьцаад ороод ирэх нь байна шүү дээ л гэдэг асуудлыг яриад байгаа юм.

Энэ дээрээ ямар байр суурь? Та хийсэн хөрөнгө оруулалтынхаа үнэлгээгээр гаргасан байна.

Тэгэхээр үүнээс илүү хөрөнгө оруулалт хийсэн олон улсын байгууллагууд яах вэ?

Хоёрдугаарт, хэлэлцээрийг нь бид ач холбогдлын хувьд нь үнэлж үзээд явуулах нь зүйтэй гэж үзэж байгаа. Гол нь доторх тэр дархан эрх, статус дээр нь хэт өргөн цар хүрээтэй орж ирсэн байна.

Тэгээд бусад байгууллага чинь яг үүнийг жишиг болгож орж ирэх юм биш үү. Энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ? Олон улсын байгууллагуудынхаа тэр дархан эрхийг байгуулсан хэлэлцээр хийсэн бусад газартайгаа ямар үндэслэлээр байгуулсан юм? Энэ газрыг харьцуулсан жишгээрээ ямар ч үндэслэлээр дипломат статус олгох гэж байгаа гэдгээ танилцуулах шаардлагатай байна л гэж үзэж байна. Хариулт авъя. Гадаад хэргийн яам.

Г.Тэмүүлэн: Индрийн микрофон. Гадаад хэргийн яам.

Ж.Соёлмаа: Одоогийн байдлаар ЖАЙКА-тай иймэрхүү түвшний дархан эрх, ямба олгох хэлэлцээр байгуулагдаагүй.

Түрүүн миний хэлснээр хөрөнгө оруулалт, эдийн засгийн ашиг хонжоо evaluate_[үнэлгээ] хийгээд тэгээд host country agreement буюу эсвэл дархан эрх олгох хэлэлцээрийг зөвшөөрөх эсэхээ холбогдох улс нь шийддэг.

Тэгэхээр таны хэлснээр өөр зарим нэг урт хугацаанд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд нь ийм санал тавих эрсдэл байгаа хувьд бол байгаа. Түүн дээр яг тодорхой судалгаа манай Гадаад яаманд хийгдээгүй.

Яг энэ GGGI-ын хувьд гэх юм бол манай яаман дээр санал нь орж ирэхэд аль улсууд ямар эрх хэмжээнд, ямар цар хүрээнд ямар хязгаараар нь эрхээ болгодог вэ талаар бусад одоо нэгдэж байсан улсуудыг нь судалж саналаа Байгаль орчны яаманд өгсөн байгаа.

Г.Тэмүүлэн: Ц.Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Би сонирхоод ганц хоёр юм нэмж тодруулъя гэж бодогдлоо.

Энэ байгууллагатай гэрээ хэлэлцээр хийгээгүй мөртлөө 150 гаруй сая долларын хөрөнгө оруулалт түрүүлээд авсан ажиллаж байгаа юм байна гэж ойлгож байна. Энэ дээр арай илүү жоохон тодорхой дэлгэрүүлээд хэлээд өгнө үү гэж хүсэж байна.

Хоёрдугаарт, энэ байгууллага өөрөө хэчнээн үнэтэй ийм байгууллага бий болох гээд байгаа болоод тэнд ажиллаж байгаа бүх хүмүүс нь дархан эрх эдэлье гэдэг ийм асуудал оруулаад, тэгээд 8, 9 жилийн хугацаанд дахин дахин ингэж орж ирээд байгаа юм бэ?

Одоо ганцхан суурин төлөөлөгч нь буюу энэ байгууллагын Монгол дахь газрын дарга нь энэ дархан эрхийг эдлээд бусад нь эдлэхгүй ээ л гэж ингэж л оруулж ирж байгаа юм байна.

Тэгэхээр энэ дээр тодорхой бүтцийн талаар мэдээллийг өгнө үү гэж хэлэх байна.

Гуравдугаарт, нарны станц барих ийм төсөл хэрэгжиж байгаа гэж байна. Сайншандад эхлээд явж байгаа юм байна. Нийтдээ 26 гаруй сая доллар гэв үү дээ. Сая мэдээллээс.

Дараа нь Дундговь аймагт хэрэгжих юм байна. Ховдод хэрэгжих юм байна.

Энэ станцуудыг барьж байгуулахаар дараа нь хэнд хариуцуулж хүлээлгэж өгдөг юм бэ? Энэ дээр мэдээлэл нэмж авъя гэсэн бодолтой байна.

Дөрөвдүгээрт нь, энэ байгууллага одоо манай Монгол Улсад болох гээд байгаа COP17 гээд олон улсын том арга хэмжээ болох гэж байгаа. Энэ арга хэмжээнд ямар оролцоотой оролцох вэ? Ер нь яаж оролцдог ийм байгууллага вэ гэдэг ийм асуултуудад хариулт авъя.

Г.Тэмүүлэн: Ц.Сандаг-Очир сайд асуултад хариулъя.

Ц.Сандаг-Очир: Монгол Улс 2013 онд Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн гишүүнээр элссэн. 2014 оноос Монгол дахь хөтөлбөрийн газрыг байгуулаад ажиллаж байна.

Хөтөлбөрийн газар нэг 4-өөс 5 хүний бүрэлдэхүүнтэй.

Тэгээд энэ 4-өөс 5 хүнийхээ бүрэлдэхүүнтэй энэ төслийн нэгждээ л дархан эрх, эрх, ямба авах гээд байсан.

Өнөөдрийн орж ирж байгаа асуудал бол бид энэ бүх хөтөлбөрийн ажилтнуудад бус зөвхөн хөтөлбөрийн удирдлагад нь дархан эрх, ямба олгох асуудлыг нь оруулж ирж байгаа.

Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн Ерөнхийлөгч нь Ерөнхий Ассамблейн даргаар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Солонгосын Бан Ги Мүн дарга ажилладаг.

Шийдвэр гаргах түвшинд Ерөнхий Ассамблей болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Ер нь энэ институт маань манай COP-той холбоотойгоор Бан Ги Мүн Ерөнхийлөгч COP-т ирж оролцохоор байгаа. Хэрвээ энэ хэлэлцээр батлагдвал хэлэлцээрт гарын үсэг зурах ажлаа COP-ийн үеэр баталгаажуулж зуръя гэсэн төлөвлөгөөтэй байна.

Тэгээд цаашдаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын тусгай хариуцлагатай байгууллага болгох өөрсдөө зорилт тавьж ажиллаж байгаа. Хэрвээ энэ хэлэлцээр батлагдвал энэ шат нь шат нэмэгдэж байна.

Нөгөө талаар манай улсад цаашдаа энэ институтээс хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, байр суурь, статусаа улам баталгаажуулах бололцоо боломжууд гарч байна.

Мэдээж өнгөрсөн хугацаанд хийгдсэн тэр хөрөнгө оруулалтын ажлууд үндсэндээ Монголд л үлдэнэ. Монголд л үлдэнэ. Цаашдаа олон ногоон санхүүжилтийн хэлбэрээр уур амьсгалын өөрчлөлтийн хууль батлагдсантай холбогдуулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр олон төсөл, хөтөлбөрүүд дээр хамтарч ажиллах тэр бололцоо, боломжууд улам нэмэгдэж баталгаажиж байна л гэсэн үг.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс нэмж хариулъя. Индрийн микрофон. Сайдын зөвлөх Д.Одхүү.

Д.Одхүү: Баярлалаа. Түрүүн асуусан асуулт дээр, тэр олон улсын хөгжлийн агентлаг болох Жи Ай Зи, КОЙКА ЖАЙКА-тай ялгаа ямар байгаа юм бэ гэдэг дээр хэлэх ёстой. Юу гэхээр Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийг Монгол Улс гишүүн орныхоо хувьд гэрээг нь соёрхон баталсан. Гишүүн

байгууллагын хэлэлцээр буюу **Establishment Agreement**^[үүсгэн байгуулах хэлэлцээр] дээрээ олон улсын эрх зүйн этгээдийн статус бүхий бие даасан Засгийн газар хоорондын байгууллага гэдэг ийм статусаар бид хүлээн зөвшөөрсөн учраас аль нэг улс, нэг улсын агентлагуудаас тэс өөр.

Тэгэхээр энэ дээр гол зарчим нь энэ байгаа шүү. Монгол Улс гишүүнээр элсээд establishment agreement-ийг нь хүлээн зөвшөөрсөн учраас энэ статусаа хамгаалах л энэ дархан эрхийн гэрээгээ л оруулж байгаа юм.

Түүнээс биш мөнгө оруулаад нэг хэдэн төсөл хэрэгжүүлж байгаа байгууллага гэдэг утгаар биш. Хэрвээ энэ гэрээг бид батлахгүй гэсэн тохиолдолд Монгол Улс тэр байгууллагаас гишүүнээсээ татгалзах, эсвэл соёрхон баталсан гэрээгээ хүчингүй болгох ийм сонин зүйл рүү явна гэсэн үг.

Тэгэхээр дахиад хэлье. Санхүүжилтийн асуудлууд чухал байгаа нь үнэн боловч Монгол Улс энэ host country agreement-ийг баталснаараа өөрийнхөө соёрхон батлаад өдий хүртэл 10 гаруй жил явж байгаа энэ олон улсын, одоо Нэгдсэн Үндэстний Байгууллагын ажиглагч, тэр эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын гээд нэр бүхий нэлээн том олон улсын байгууллагуудын ажиглагч байгууллагынхаа статусыг хадгалж үлдэх эрх зүйн орчноо бүрдүүлэх гэсэн ийм асуудал байгаа юм л гэж тодруулах гэсэн юм.

Г.Тэмүүлэн: Ц.Мөнхбат гишүүн нэмж тодруулъя.

Ц.Мөнхбат: Монгол Улсад оруулаад байгаа 150 орчим сая доллар өөрөө зээл юм уу, буцалтгүй тусламж байдаг юм уу? Ямар хэлбэрээр явдаг юм бэ?

Хоёрдугаарт нь, сэргээгдэх эрчим хүчний чиглэлийн станцууд баригдах юм байна шүү дээ.

Энэ баригдаад явахлаараа дараа нь ашиглалтад орж таарна. Ашиглалтыг хэн хариуцаж явах вэ? Дараа нь. Энэ дээр Та бүхэнд нэмэлт мэдээлэл өгөх боломж байна уу?

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс хариулъя. Индэрийн микрофон.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын яам. Ш.Батбаяр. Гишүүний асуултад хариулъя.

Өнгөрсөн хугацаанд оруулж ирсэн төсөл, хөтөлбөрүүд дандаа грант буюу буцалтгүй тусламжаар орж ирсэн байгаа.

Монгол Улсад хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүд орон нутгийн өмч буюу тухайн төрийн захиргааны байгууллагууддаа үлдэж байгаа. Жишээ нь, 2018 онд Эрчим хүчний яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам хамтраад нийслэл хотод төвлөрсөн дулаанаас алслагдмал байрлал бүхий Сонгинохайрхан

дүүргийн 122 дугаар сургуульд газрын гүний дулааны асуудлыг шийдээд тухайн сургуульдаа хүлээлгэж өгсөн байгаа.

Хэлэлцээр баталснаар томоохон хөтөлбөрүүд рүү орно. Тэр үед тухай тухайн төслүүд дээрээ хүлээж авах байгууллагуудаа сонгоод явна.

Орон нутагт баригдаж байгаа туршилтын станцыг орон нутагт нь хүлээлгэж өгнө. Бусад томоохон төсөл, хөтөлбөрүүдийг төсөл, хөтөлбөр тус бүр дээр нь ярьж явна. Хэрэгжүүлэгч байгууллагуудтай.

Г.Тэмүүлэн: П.Наранбаяр гишүүн асуулт асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Дархан эрх, ямба олгох тухай асуудал яригдаж байна.

Тэгэхээр урьд нь хэд хэдэн удаа орж ирээд буцаж байсан түүхтэй ийм зүйлийг өнөөдөр ярилцаж байна.

Урьд нь орж ирээд буцаж байсан түүхтэй бол Засгийн газраас, ялангуяа Байгаль орчин, ногоон хөгжлийн яам хавсаргасан баримтуудаа бүрэн өгөхгүй яасан юм бэ? Нэг нүүр хүрэхгүй нэг танилцуулгатай. Тэгээд ямар ч мэдээлэл байхгүй тэр нь. Тэгээд тэр байгууллагын түүх нь ч байхгүй. Сая асууж байж нэг юм хариулж байна.

Тэгэхээр олон улсын гэрээний эрх тухай Монгол Улсын хуульд байдаг бүрдүүлбэрийг бүрэн хангаж Байнгын хорооны хурал руу оруулах шаардлагатай. Яагаад ийм материал, ийм нэгхэн нүүр материал бэлдэж оруулж ирсэн юм бэ? Нэгдүгээрт үүнийг асууя.

Хоёрдугаарт, GGGI гээд Даян дэлхийн ногоон хөгжлийн институт гээд байгууллага. Энэ байгууллагын үүсгэн байгуулсан гэрээний 15 дугаар зүйлийг хэлье.

GGGI нь төв байртай улсад шаардлагатай дархан эрх, ямба эдэлнэ гэж заасан. Тэр нь Сөүлд байдаг. Энэ бол зайлшгүй хийх ёстой. Үүргээрээ дархан эрх, ямбыг Солонгос Улстай байгуулна гэсэн үг. Өмнөд Солонгос улстай.

Бусад гишүүн оронд мөн ийм эрх, ямбыг тусгай гэрээ. Түрүүн Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дарга хэлээд байна шүү дээ. Host country agreement. Тусгайлсан гэрээ байгуулсан бол болно.

Байгуулсан тохиолдолд “эдэлнэ” гэж заасан байтал. Энэ чинь 15 дугаар зүйл дээрээ зүгээр “байгуулсан тохиолдолд эдэлнэ” гэсэн. “Заавал байгуул” гэж огт хэлээгүй үед яагаад үүнийг байгуулахгүй бол юмаа хаагаад явчихна гэж ингэж мушгин гуйвуулж тайлбарлаад байна вэ? Үүнийгээ тодруулж хэлмээр байна. Ингэж болохгүй шүү дээ. Энэ тоглоом биш шүү дээ. Үүсгэн байгуулагчийн

гэрээний 15 дугаар зүйл дээр олон улсын гэрээ хэлэлцээр нь ийм байж байхад ингээд хийж байдаг.

Хоёрдугаарт, энэ байгууллага судлаад үзэхэд үнэхээрийн сайн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг юм байна. Шууд хөрөнгө оруулалт бол хийдэггүй юм байна шүү дээ. Одоо тэр 150.0 сая доллар чинь бол шууд хөрөнгө оруулалтууд биш. Дандаа зөвлөх үйлчилгээ үзүүлж, тэгээд энд тэндээс мөнгийг нь татаж авахад нь туслалцаа үзүүлээд, тэгээд 150.0 сая доллар хөрөнгө оруулалт Монгол руу орж ирсэн болохоос биш энэ байгууллага шууд өөрөө хөрөнгө оруулалт хийсэн юм шигээр ингэж тайлбарлах нь хүмүүст буруу, зөрүү ойлголт өгөхөөр байна шүү гэдгийг анхааруулъя.

Тэгэхээр энэ асуултуудад хариу авмаар байна.

Эцэст нь “дипломат эрх”. Өөрөөр хэлбэл “дархан эрх”. Энэ “эрх, ямба” гэдэг хоёр ойлголтыг ялгаж салгаад бидэнд тайлбарлаад өгмөөр байна. Ялгаж салгаад. “Дипломат дархан эрх” гэдэг чинь өөр асуудал.

Миний ойлгож байгаагаар тухайн улсын шүүхийн юм уу, захиргааны аливаа нэгэн дарамтад орохгүй ээ л гэсэн үг. Тэр хүнийг баривчлах эрх байхгүй. Гэтэл өөр ойлголт. Тэр консулынх нь байдаг ойлголт бол баривчлах эрхтэй. Гэхдээ дипломат статустай ингэж явж байдаг.

Ийм ойлголтыг ялгаж салгахгүй бол эрх, ямба, дархан эрхийн тухай гээд нийлүүлээд ороод ирж байгаа байхгүй юу. Энэ зүйлээ Та бүхэн маань анзаараач ээ.

Гуравдугаарт нь, энэ байгууллагын өөрийнх нь дарга. Эцсийн асуулт нь, энэ байгууллагын өөрийнх нь санхүүжилт нь хэрхэн явдаг юм. Энэ чинь **Intergovernmental organization (IGO)** байна. IGO-г Засгийн газар хоорондын ийм.

Тэгэхээр энэ улс орнууд өөрсдийнхөө дистрибьюшн буюу тэр төлөх ёстой мөнгийг төлж байх ёстой. Монгол Улс хэдийг төлдөг юм? Жилдээ.

Тэгээд энэ хэрхэн санхүүждэг юм?

Мөн Монголд өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад нь чухам хэдэн хүн байгаа юм? Үүнээс яг дипломат эрхийг нь. Өөрөөр хэлбэл шүүх захиргаа нь янз бүрийн дарамтад орохгүйгээр баривчлагдахгүй гэдэг дархан эрхийг нь хэд нь эдлээд, бусад нь ямар эрх эдлэх юм? Ийм зүйлийг асуумаар байна.

Тэгээд эцэст нь яг үүнийг байгуулах юм бол ар араасаа зөвхөн IGO ч биш, олон улсад их хүчтэй үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагууд ч гэсэн ийм шаардлага тавьж орж ирэхийг үгүйсгэхгүй.

Тийм учраас энэ дээр оруулж ирж байгаа материал юмнуудаа аягүй сайн оруулж ирээч ээ. Ганцхан нүүр танилцуулгатай. Тэгээд өөрсдөө үлдсэнийг нь бүгдийг нь өөр өөр эх сурвалжуудаас харж байна шүү дээ. Бид.

Тэгэхээр ийм зүйлийг ингэж яаравчилж оруулж ирж байгааг ойлгож байна. Одоо энэ COP17-гийн үеэр гарын үсэг зурах. Бан Ги Мүн гэдэг бол том зүтгэлтэн. Ойлгож байна. Гэхдээ энэ асуудлыг бид төрийн зарчмаар нь л явах ёстой гэж харж байгаа учраас энэ асуултуудыг асуугаад байгаа юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг хариулъя. Индрийн микрофон.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам. Ш.Батбаяр гишүүний асуултад хариулъя.

2025 оны 5 сард Засгийн газрын хуралдаанаар орсон асуудал байгаа. Тухайн үед манай яамнаас уг асуудлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу бүрдүүлбэрийг хангуулан Засгийн газрын хуралдаанаар оруулж батлуулсан байгаа.

Хоёрдугаарт, энэ байгууллагын хөрөнгө оруулалтын бүтэц ямар вэ гэвэл хоёр хэсгээс бүрдэж байгаа. Үндсэн төсөв нь хандивлагч орнуудын санхүүжилтийг 50 хувиар авч байгаа. Хоёр дахь хэлбэр нь эх үүсвэр татах гэж байгаа. Олон улсын уур амьсгалын ногоон сан, Дэлхийн банк, Дасан зохицох Сан, The Nature Conservancy гээд олон байгууллагуудаас үлдсэн 50 хувийнхаа санхүүжилтийг босгодог системтэй байгаа.

Манай улсын Засгийн газар ямар нэгэн хэлбэрээр санхүүжилтийн үүрэг хүлээгээгүй байгаа. Хэлэлцээр дээр.

Бусад дипломат байгууллагын эрх, ямбатай холбоотой асуудлыг Гадаад яам хариулна.

Ж.Соёлмаа: П.Наранбаяр гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, GGGI гээд өнөөдөр бид хэлэлцэж байгаа байгууллагын хувьд 50 гаруй улс гишүүнчлэлтэй. Үүнээс өнөөдрийн тоо баримтаар 25 улстай host country agreement буюу тусгайлсан эрх, ямба өгсөн зохицуулалт байна гэсэн мэдээлэлтэй байна.

Дараагийн ээлжинд “дипломат эрх” буюу “immunity” нь тухайн субъектийг шүүхийн аливаа үйл ажиллагаанаас чөлөөлөх, тэгээд бие болон түүний захидал, харилцаа холбоо, бүх юм нь халдашгүй дархан байх гэсэн ийм ойлголт.

Хоёр дахь ойлголт буюу “дипломат эрх, ямба” буюу “privileges” нь гаалийн татвар хураамж болон бусад төрлийн татвар хураамжаас чөлөөлөгдөх гэсэн ийм хоёр тусдаа ойлголт байгаа юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Нэмээд Ж.Соёлмаа захирал хариулах уу? Өөр байгууллагууд ижил төстэй хүсэлт тавих эсэх асуудлууд дээр Гадаад харилцааны яам.

Ажлын хэсэг нэмж хариулъя. Хэн хариулах вэ? Гараа өргөөрэй. Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Хэн хариулах вэ?

Ш.Батбаяр: GGGI байгууллагын зүгээс олон жилийн хугацаанд хэлэлцээрийг Монгол Улсын Их Хурлын зүгээс батламжилж өгөөгүй учраас энэ оны 12 дугаар сараас эхлээд манайх энэ үйл ажиллагаагаа зогсооё гэж манай талд мэдэгдсэн байгаа юм.

Хоёрдугаарт, жишээ болгож татах орнууд бол сая хэлсэн.

Азийн бүсэд – Лаос, Энэтхэг, Индонез, Тайланд, Филиппин.
Европоос – Унгар, Люксембург, Хойд Македон.
Латин Америкаас – Колумб, Коста Рика, Мексик, Доминикан.
Дундад Азиас – Кувейт, Арабын Нэгдсэн Эмират

-зэрэг улсуудыг баталсан байна. Уг хэлэлцээрийг.

Г.Тэмүүлэн: П.Наранбаяр гишүүн нэмж тодруулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр хоёр зүйлийг л дахиад тодруулъя. Дахин дахин асууя.

Нэгд нь, тэр 150.0 сая доллар бол зөвлөх үйлчилгээгээр дамжиж орж ирсэн хөрөнгө оруулалт уу? Эсвэл энэ байгууллага шууд хөрөнгө оруулалт хийдэг юм уу гэдгийг хариулаад өгөх хэрэгтэй байна.

Хоёрдугаарт нь, үүсгэн байгуулахад анх оролцож байгаа Засгийн газрууд очиж гарын үсэг зурдаг. Тэрний 15 дугаар зүйл дээр зайлшгүй дипломат дархан эрх, ямба. Үүнийг эдлэх нь Сөүлд байгаа, өөрөөр хэлбэл төв байртай улс тэрийг эдэлнэ. Тэрийг заавал гаргаж өгнө. Бусад гишүүн улсууд бол host country agreement буюу хүлээж авч байгаа улстай тусгайлсан гэрээ байгуулсан тохиолдолд эдэлнэ гэсэн заалт байгаа байхгүй юу.

- “Тохиолдолд эдэлнэ” гээд заасан байгаа заалттай үед яахаараа заавал энэ гэрээг хийхгүй бол бид хаана гэж ярьж байгаа юм бэ?
- Тэгээд одоо хэдэн хүн чухам яг энд ажиллаад байна вэ?
- Шүүхээс ангид, цэрэг цагдаагаас ангид байдаг тэр дипломат халдашгүй дархан эрхийг эдлэх нь хэдэн хүн бэ?
- Тэгээд нөгөө нь хэдэн хүн бэ гэдгийг л асуугаад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг асуултад хариулъя. Индрийн микрофон.

Ш.Батбаяр: Хөрөнгө оруулалтын хувьд үнэн. Энэ байгууллага зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Гэхдээ 2014-2025 оны хугацаанд салбарын бодлого, үндэсний хөтөлбөр боловсруулах, үнэлгээ суурь судалгаа хийх ажилд 11 сая долларын хөрөнгө оруулалтыг өөрөөсөө гаргасан. Үлдсэнийг нь зөвлөх үйлчилгээний шугамаар оруулж ирсэн.

Г.Тэмүүлэн: Ц.Сандаг-Очир сайд микрофон дээр хариулъя.

Ц.Сандаг-Очир: Энэ хэлэлцээрийг батлуулахаар манай улсад саналаа тавиад 9 жил өнгөрч байгаа юм байна.

Тэгээд өнөөдрийг хүртэл шийдэж чадаагүй байгаа.

Тэгээд энэ олон жил, үндсэндээ 10 жил болж байгаа. Энэ хугацаанд үнэхээр хэлэлцээр баталж өгөхгүй бол 2026 оны төгсгөлд 12 сараас үйл ажиллагаагаа, үндсэндээ хөтөлбөрөө зогсооно гэдэг мэдэгдлийг яаманд ирүүлчхээд байж байгаа. Тийм.

Тийм учраас бид өнгөрсөн хугацаанд. Монголд л орж байгаа хөрөнгө оруулалт. Олон хуулийн төслүүд дээр зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Тодорхой зарим хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалтын ажлууд хийсэн.

Ер нь Монгол Улсад цаашдаа хуультай болчихлоо. Анхдагч.

Ер нь ногоон хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаанууд явуулах бололцоо боломж энэ хэрээр нэмэгдэнэ. Хөрөнгө оруулалтыг татах бололцоо боломж нэмэгдэнэ. Энэ чинь энэ олон улсын ногоон санхүүжилтийн байгууллагуудаас л хөрөнгийг зуучилдаг, олдог ийм байгууллага.

Тийм учраас ер нь үлдэж байгаа хөрөнгө нь Монгол Улсад л үлдэж байгаа. Түүнээс хэнээс, хаанаас энэ байгууллага оруулж байна вэ, эсвэл тэр донор орнуудаас олж байна уу гэдэг нь тийм чухал биш.

Ер нь хөрөнгө оруулалтыг татаж, тухайн гишүүн улс орнууддаа энэ чиглэлээрээ үйлчилгээ үзүүлдэг ийм институт л юм байна.

Тийм учраас бид энэ хэлэлцээрийг нь. 4-өөс 5 хүн энэ хөтөлбөрт ажилладаг гэж байгаа. Анх санал тавихдаа энэ бүх ажилтнууддаа дархан эрх, ямбын асуудлаа тавьсан. Манайхаас хэд хэдэн удаа буцаасан учраас бид өнөөдөр зөвхөн хөтөлбөрийнх нь удирдагчид нь энэ дархан эрх, ямбын олгох асуудлыг нь ярьж байгаа. Бусад ажилтнууд нь больё гэдэг ийм байдлаар. Нөгөө талаас ч гэсэн үүнийг үлээн зөвшөөрөөд ингээд явж байгаа юм.

Г.Тэмүүлэн: С.Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Энэ Их Хурлын гишүүд улдан эсэргүүцээд ч юм уу, жадлан сөрөөд байгаа юм байхгүй шүү дээ.

Хангалттай мэдээлэлгүй байна. Гадаад яам ч тэр, Уур амьсгалын яам ч тэр өгч байгаа мэдээлэл нь дулимаг байна. Ядаж мэдээлэл муутай хүмүүст нөгөө даян дэлхий энэ тэр гээд эхлэхээр чинь нөгөө Мүүнийхэн чинь Монголд яаж орж ирлээ. Бүр сүүлдээ Монгол Улсын төв талбай дээр асар том үйл ажиллагаа тухайн үеийн Ерөнхийлөгч нарын ивээл доор нь хийдэг. Монгол Улсын Их Хурлын гишүүн нь хүртэл очоод UB Palace-т арга хэмжээг хөтлөөд. Манай улсын төрийн маш олон өндөр дээд албан тушаалтнуудыг өөрсдийн зардлаараа гадаад улсууд руу явуулаад, удаа дараа манай улсын төрийн бодлогод нөлөөлөх гэж, оролцох гэж хичээж байсан шүү дээ. Гашуун түүх.

Тэгээд сүүлд нь тэр байгууллага олон улсын түвшинд ямар нөхцөл байдал гарлаа. Ямар холбооны, ямар далд бизнесийг гоёчилж харуулдаг сүлжээ болох нь нотлогдлоо. Бид улс төрчдөө намнахдаа хүртэл Мүүнтэй холбож намнасан гашуун түүх байгаа шүү дээ.

Тэгэнгүүт одоо ядаж байхад даян дэлхий байгууллагын нэрний орчуулга нь GGGI-г нь монголоор орчуулахаар ингээд ороод ирэнгүүт бид энэ хэлэлцүүлэг, Байнгын хорооны хурлаар жирийн иргэддээ ч гэсэн мэдээлэл өгөх ёстой шүү дээ. Юу нь мэдэгдэхгүй нэг юм баталдаг юм шиг хүмүүст ойлгуулж болохгүй шүү дээ. Нэгдүгээр асуудал.

Тийм учраас Ч.Анар гишүүний асуугаад байгаа, П.Наранбаяр сай сайдын асуугаад байгаа юм чинь тийм учиртай шүү дээ.

Манай улс чинь Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт тусгаар тогтносон орон. Өөрийн гэсэн аюулгүй байдал, эрх зүйн халдашгүй дархан байдалтай, өөрсдийн гэсэн шалгууртай шүү дээ.

Тэгээд энэ байгууллагатай. Мэдээж ойлгож байна л даа. Монгол Улсад хөрөнгө оруулах гэж байгаа. Гэхдээ яг ингээд... өө..., за за, шантаажлаад байдаг юм аа. Гарч явна гэсэн гээд байх юм бол яах юм. Түрүүний асуусан КОЙКА тэгэх юм уу, ЖАЙКА тэгэх юм уу, ТИКА тэгэх юм уу.

Энэ чинь өөрөө президент жишиг үүсчихвэл яах юм? Тэгээд 25 улсыг нь сонсохоор ихэнх нь Азийн орнууд байгаа юм байна. Европоос Унгар эд нар гээд цөөхөн орнууд байгаа юм байна.

Тэгэхээр өмнө нь буцаагдсан асуудлыг яагаад ийм гүехэн судалгаатай оруулж ирж байгаа юм? Beyond a reasonable doubt гэсэн ойлголт байдаг шүү дээ. Хөдөлшгүй нотлох баримтаар асуудлыг шийддэг. Олон улсынхан мэдэж байгаа шүү дээ. Яамныхан. Яах вэ, уур амьсгалын яамныхыг биш. Гадаад харилцааны яам энэ дээр шүүлтүүртэй хандах ёстой шүү дээ.

Тэгээд тэр шүүхийн асуудал. Тэр чинь эрх, ямбын асар онцгой зүйл шүү дээ.

Тэгээд окэй энэ байгууллага орж ирлээ. Тэр даргад нь эрх, ямба өглөө гэхэд тэгээд яах юм. Монголын хууль дээгүүр гишгээд явах юм уу?

Бүгд Найрамдах Солонгос Улсын олон улсын лобби суваг. Та нар өөрсдөө судлаад үз. Би сүүлийн 2 жил энэ байгууллагыг мэдэж байна. 2 жилийн өмнө Ван Ги Мүн гуай Монголд ирээд Чингис хааны одон аваад явсан. Тэр хүн 2007-2017 оны хооронд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллахдаа Монгол Улсад ээлтэй тустай олон олон зүйлүүдээр оролцсон. Тэр хувь нэмэр итгэл үнэмшлийг Монголын ард түмэн үнэлж байна. Сайшааж байна, хайрлаж байна.

Гэхдээ Бүгд Найрамдах Солонгос Улсын лобби энэ зүйлийг шууд одоо бид ийм бусад нэг улсын, олон улс руу гаргаж байгаа гэдэг энэ ковер байгууллага дээр дархан эрх өгөөд байж болох юм уу? Бид чинь Их Хурал дээрээ нэг асуудлыг ярьж байна шүү дээ. Шууд утгаараа. Энд ажиллаж байгаа би Д.Одхүү гуайг хүндэлдэг. Ж.Соёлмааг хүндэлдэг. Сайдыг бас энэ салбартаа юм хийх гээд явж байгааг ойлгож байна.

Тэгэхдээ дараа нь энэ асуудалд Та нар дээр хариуцлага болж очно шүү. Мөнгө яах вэ, олдож болно, асгаж болно. Гэхдээ нэг л үүнийг зөрчих юм бол бид президент үүсгэхинэ шүү гэдгээ та нар бодоорой.

Г.Тэмүүлэн: С.Эрдэнэболд гишүүн үг хэллээ.

Би Гадаад харилцааны яамнаас нэг, хоёр зүйлийг тодруулж асуугаадахъя.

Бид бүхэн яг энэ асуудалтай холбогдуулаад Хууль зүй, дотоод хэргийн яамнаас, Гадаад харилцааны яамнаас, Сангийн яамнаас тодорхой тодруулга мэдээллүүдийг авсан юм.

Тэгээд энд хариулсан хариултууд дотроос би Гадаад харилцааны яамны ирүүлсэн тайлбар мэдээг би хангалтгүй гэж үзээд байгаа юм.

Танай яамны 6 сарын 03-ны өдөр ирүүлсэн бичиг дээр Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээрийг байгуулах саналыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам гаргасан тул тус яамнаас мэдээлэл авах нь зүйтэй гэсэн ийм байр суурийг бичиг нэрээ ирүүлсэн. Доор нь тус байгууллага нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд хамаарахгүй болно гэсэн хариу өгсөн.

Уг нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20.5 дахь хэсгийн 8-д заасны дагуу Гадаад харилцааны сайд эрхлэх асуудлынхаа хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагатай гэрээ хийх хэлэлцээрийн асуудал болон байгуулсан гэрээ хэлэлцээрийн явцад хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлэх гэж байгаа.

Мөн дээрээс нь Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 3.3.2.9-д Монгол Улсад суугаа гадаадын Дипломат төлөөлөгчийн газруудын эрх, ямба халдашгүй дархан эрхтэй холбогдсон асуудлыг зохицуулах чиг үүрэг юм уу хэрэгжүүлэх үүрэгтэй гээд заасан байгаа юм.

Тэгээд үүнийг манай Хууль зүй, дотоод хэргийн яамнаас яг үүнийг онцолж өгсөн байгаа.

Тэгэхээр яг Гадаад харилцааны яам яг энэ эрхлэх асуудлынхаа хүрээнд яг ямар байр суурьтай байгаа юм бэ? Бид Байнгын хорооны гишүүдээс ч гэсэн энэ асуудлыг хөндөж яриад байна.

Яг хуулиар олгосон заасан эрх үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд, хяналт тавих эрхийнхээ хүрээнд, зохицуулах чиг үүргийнхээ хүрээнд Гадаад харилцааны яам энэ дээр тодорхой байр сууриа илэрхийлэх ёстой байгаа юм. Энэ дээр нэг Ж.Соёлмаа дарга нэг хариулаач.

Ж.Соёлмаа: Байнгын хорооноос тухайн байгууллагын статусын талаар асуулт тодруулга ирүүлсэн байсан.

Тэр хүрээнд нэгдүгээрт энэ бол яг албан ёсны Нэгдсэн Үндэстний Байгууллагын харьяа байгууллага биш гэдэг тодруулгыг өгсөн.

Дараагийн ээлжид олон улсын гэрээний тухай хууль дээр аливаа гэрээ конвенцод нэгдэж орохдоо тухайн асуудлыг төрийн захиргааны төв байгууллага нь өөрөө судалгааг нь хийгээд, хэрэгцээ шаардлагыг нь, үнэлэлт, дүгнэлтийг нь хийгээд тэгээд Гадаад харилцааны яам, Хууль зүйн яаманд ирүүлээд манайхаас энэ саналууд боловсруулдаг.

Өмнөх хэлэлцүүлэг дээр би өөрөө оролцож байгаагүй ч гэсэн тодорхой манай Гадаад яамны байр суурь ямар байсан бэ гэхээр бид Байгаль орчны яам өөрөө тухайн салбарыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хувьд гэх юм бол энэхүү эрх, амбыг нь өгөөд энэхүү үйл ажиллагааг нь өргөжүүлэх нь зүйтэй юм байна гэсэн ийм эдийн засгийн тооцоолол нотолгоонуудаа гаргасан.

Нарийн яг хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад үр ашигтай зүйлс юу байна гэдэгт бүх зүйлсийг бид нарт мэдээллийг нь өгсөн.

Тухайн үед буюу 2 жилийн өмнө Байнгын хороон дээр хэлэлцүүлэхэд манай яамны байр суурь бид нэгдүгээрт эрх, яамын лимитэд хүрээнд өгөх ёстой. Тэр дотроо local staff буюу бид олон улсын байгууллагын local staff буюу Монгол Улсын иргэнд татвараас чөлөөлөгдөх, эсвэл ямар нэгэн нийгмийн даатгал эд нараас чөлөөлөгдөх зохицуулалтыг оруулах боломжгүй ээ. Тийм жишиг ерөөсөө аль байгууллагад байхгүй учраас энэ зохицуулалтуудаа өөрчил гэсэн ийм саналыг хэлсэн.

Тэр дагуу мөн тухайн саналаа хэлэхдээ өнөөдрийн ярьж байгаа тэр хорин хэдэн host country agreement байгуулсан улсууд нь яг нэг загвар agreement байгуулдаг юм уу, эсвэл улс болгон арай өөрөөр дээш, доош тийм лимиттэй гэрээнүүд байгуулдаг юм уу, үгүй юу гэдэг дээр судлаад ерөнхийдөө улс болгон өөрийнхөө асуудалд хамаарсан нэмэлт, өөрчлөлтийг тэр agreement нь загварт нь оруулдаг юм байна. Тийм юм чинь манайх ч гэсэн өөрийнхөө Монгол Улсын эрх ашгийг шингээсэн заалтуудыг оруулаач ээ гэсэн ийм саналыг тухайн үед нь Байгаль орчны яаманд өгч байсан.

Тэгээд тэр дагуу Байгаль орчны яам тухайн agreement-д байсан нэлээн өргөн хүрээний хөнгөлөлтүүдийг хасаад ингэж шинээр оруулж ирж байгаа гэсэн ойлголттой байгаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу? Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад. Б.Батбаатар гишүүнээр тасаллаа. Ч.Анар гишүүн.

Ч.Анар: Энэ хэлэлцээрийг явуулахгүй гээд байгаа асуудал байхгүй гэж харж байгаа юм.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч айлчлах гэж байгаа. Санаачилж нь гаргасан институт учраас бид хүндэтгэлтэй хандаж байгаа. Гэхдээ энд ямагт Монгол Улсын язгуур эрх ашиг бидний хувьд эхэнд тавигдах ёстой гэдгийг хэлье.

Одоо яах вэ, миний саналаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад энэ хэлэлцээрийг явуулах гэж юу юугүй хөнгөн хандаж явуулмааргүй байна. Бид энэ хэлэлцээрийг батлахгүй гэж санал хураахаасаа илүү дахиад Гадаад хэргийн яамнаас байр суурь нь ямар байгаа юм.

Сая дурдаж байна. Улс болгон өөр өөр байдаг бол бид ямар хэлэлцээр зүйл, заалтыг нь хассан юм. Ямар зүйл, заалтаар байгаа юм. Ямар эрхийг нь олгох ёстой юм. Олгох ёсгүй юм гэдэг тэр зарчмуудаа бид Гадаад хэргийн яамнаас харьцуулсан хүснэгттэйгээр, мэдээлэлтэйгээр авч байж шийдвэр гаргах нь зохистой болов уу гэж бодож байна.

Тийм учраас Монгол Улсын аюулгүй байдлын асуудлыг хэлэлцэж байгаа. Бид өөрсдөө тэр талаасаа харах нь зүйтэй, зохистой юм болов уу гэсэн саналтай байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Б.Тулга гишүүн үг хэлье.

Б.Тулга: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрье.

Би 2012-2014 онд Байгаль орчин, уур амьсгалын дэд сайд хийж байсан хүн байгаа юм.

Тэгээд Даян дэлхийн ногоон хөгжлийн санаачилга байгууллагыг анхнаас нь, байгуулахаас нь өгсүүлээд Монгол Улсын идэвхтэй оролцоог хангахад энэ байгууллагаар дамжиж дэлхий нийтэд бий болсон байгаа, уур амьсгалын эсрэг тэмцэж байгаа гэдэг юм уу, гарсан санал, санаачилга шинэ юуг Монгол Улсад нутагшуулах, Монгол Улсад тулгамдаж байгаа сорилтуудыг давж гарахад дэлхийн санхүүжүүлэгч байгууллагууд, донор орнуудад лобби хийх, нөлөөлөл хийх, Монгол Улсад хэрэгжиж болохуйц төслүүдийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу бэлдэж ТЭЗҮ-г нь боловсруулах, судалгааг нь хийх, Монгол Улсын энэ ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох хууль эрх зүйн орчныг сайжруулахад идэвхтэй туслагч маягаар мэдээж энэ ажиллагааг эхлүүлж байсан.

Өнөөдрийг хүртэл 10-аад жил идэвхтэй сайн явсан байна. Энэ хооронд 2012 онд байгуулагдсан GGGI байгууллага маань өөрөө ч гэсэн. 16 улс эхэлж байсан бол өнөөдрийн байдлаар 50, 60 улс гараад явж байна гэдэг бол энэ олон улсын байгууллагын түвшинд аваад үзэх юм бол маш амжилттай явж байгаа ийм байгууллага байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр харамсалтай нь энэ байгууллагыг шашны байгууллагатай, Мүүний байгууллагатай харьцуулж ярьж, аюулгүй байдалтай холбож ярьж байгаа нь аягүй харамсалтай сонсогдож байна. Эрхэм гишүүд ээ.

Тэгэхээр үүнийг зөв ойлго оо. Ер нь Гадаад яам, Байгаль орчны яамд жоохон шүүмжлэлтэй хандмаар байна. Та бүхэн дутуу мэдээлэл, материал маш дутуу оруулж ирсэн байна шүү.

Ийм сайн явж байгаа, ялангуяа уур амьсгалын өөрчлөлт дэлхийн бүх улс орнуудад, бүр Монгол Улсад ч гэсэн малчин айлын өрхийг тогшиж байгаа энэ үед яг энэ дээрээ тэргүүлэх чиглэлээр ажиллаж байгаа ийм байгууллагаа бүрэн танилцуулж чадахгүй. Үүнийхээ одоо юу гэдэг юм, олон улсын байгууллага, нэг улсын тусламжийн байгууллага хоорондын ялгааг гаргаж хэлж чадахгүй гишүүдийг мэдээллээр дутуу хангаж байгаад Та бүхэнд шүүмжлэлтэй хандаж байна.

Сая би асуулт авсангүй л дээ. Уг нь дэмжье гэж бодоод суугаад.

Энэ байгууллага Азийн хөгжлийн банк, Европын Хөгжлийн Банк, энэ байгууллагуудтай ижил статустай буюу олон улсын байгууллага.

Түрүүн энэ юунд гарч байгаа, манайд дурдагдаад байгаа, тусламж үзүүлж байгаа гэж байгууллагууд тухайн нэг улсын, тухайн хөгжиж буй оронд техникийн туслалцаа үзүүлж байгаа байгууллагууд шүү дээ. КОЙКА, ЖАЙКА, Жи Ай Зет, Швейцарын хөгжлийн гэдэг чинь дандаа тухайн улсынхаа технологийг Монгол Улсад өөрсдийнхөө мөнгийг гаргаад тусламж үзүүлдэг байгууллагууд.

GGGI юугаараа ялгаатай вэ гэхээр энэ байгууллагуудыг зөвхөн тэр тухайн улсын нөлөөнд гэдэг юм уу, лоббинд оруулалгүйгээр дэлхий дээр байгаа хамгийн сайн туршлагуудыг Монгол Улсад яаж нэвтрүүлэх вэ гэдэг дээр л дэмжиж техникийн туслалцаа үзүүлж байгаа байгууллага.

Тэгэхээр энэ бол шууд донор гэхээсээ илүү бид энэ байгууллагатай хамтарч ажиллаж байж Монгол Улсын ногоон хөгжлийг, Монгол Улсын уур амьсгалтай тэмцэх энэ тэмцэлд хувь нэмэр оруулах ийм л үүрэгтэй байгууллага шүү дээ. Нэг их олон ч хүн байхгүй.

Тэгэхээр их олон жил яригдаад дэмжиж гишүүнээр орсон мөртлөө нөгөө талаас тавьж байгаа, хүсэж байгаа танайх одоо тэр нэг дипломат эрх юуг нь бусад олон улсын байгууллагатай ажиллагаа өгөөч гэхээр бид энэ дээр аюулгүй байдал яриад, энэ дээр Мүүний шашны байгууллагатай яриад үүнийг гацаах нь жоохон бүдүүлэг л харагдаж байгаа хэлбэр шүү. Үүнийг манайхан их сайн ойлгоорой.

Тэгээд дахин хэлье. Манай асуудал оруулж байгаа нөхдүүд танилцуулга маш дутуу байна.

Тийм учраас гишүүд ийм ойлголттой байх нь аргагүй.

Тийм учраас эрхэм гишүүддээ одоо энэ хаврын чуулган дээр энэ оруулж ирж байгаа асуудлыг дахин дахин хойшлуулалгүйгээр Та бүхэн дэмжиж өгөөч ээ. Тэртээ тэргүй дэлхийн олон улсын байгууллагын чиг хандлага аягүй өөр болж байгаа. Улс улс гишүүн гэдэг байдлаасаа илүү тухайн асуудлаар нэгдэж олон улсын байгууллагууд хөгжих ийм шинэ төлөв хандлага гарч байна.

Анх бий болгож байсан 16 байгууллага Бразильд Риод болсон хурлаас Англи, Австрали, тэгээд маш олон нөлөө бүхий улсуудад нэгдэж энэ байгууллагыг санаачилсан байгаа шүү.

Түүнээс биш зөвхөн одоо юу гэдэг юм энэ юуны гишүүнээр зөвхөн хөгжиж буй хамгийн буурай хөгжилтэй улсууд биш шүү гэдгийг хэлье. Мэдээж Солонгос Улстай бид хамтарч ажиллах ёстой.

Г.Тэмүүлэн: Тэгье. Б.Тулга гишүүн 1 минут.

Б.Тулга: Бүгд Найрамдах Солонгос Улс Монгол Улсын гурав дахь хөрш. Мэдээж эдийн засгийн тал дээр, ногоон хөгжлийн тал дээр дэлхий дээрээ өөрөө тэргүүлэх тоглогчдын нэг байгаа.

Тийм учраас зүгээр нэг улсын лобби гэж ойлгохоосоо илүү энд нэгдэж орсон 50 гаруй улсын одоо хамтын зорилтыг дэмжиж Монгол Улс байх ёстой.

Тэртээ тэргүй гишүүнээр байгаа. Одоо энд удирдаж байгаа байгууллагын тэргүүнд нь дипломат юу олгох нь тийм аймаар хүндрэлтэй гэдэг юм уу, аюулгүй байдалд заналхийлсэн гэдэг юм уу, учиргүй Монгол Улсын шүүх, хууль тогтоомжийг зөрчих гээд байгаа асуудал биш юм гэдгийг Та бүхэндээ хэл хэлмээр байна.

Тэгээд СОР болж байгаа. Солонгосын Ерөнхийлөгч ирж байгаа.

Одоогийн байдлаар Бан Ги Мүн Ерөнхийлөгч тэр үед Ерөнхийлөгч нь байгаагүй. Одоо Ерөнхий нарийн бичгийн дарга байсан Бан Ги Мүн гуай Ерөнхийлөгч нь болсон байгаа юм байна.

Тэгэхээр энэ хүний network, энэ хүний давуу тал, энэ байгууллагын давуу талыг бид тултал ашиглах ёстой.

Тийм учраас Байгаль орчин, уур амьсгалын яамныхаа оруулж ирж байгаа энэ саналыг эрхэм гишүүд маань дэмжиж өгөөч ээ гэж дэмжиж үг хэлж байна. Баярлалаа Та бүхэнд.

Г.Тэмүүлэн: Б.Тулга гишүүнд баярлалаа. П.Наранбаяр гишүүн. баярлалаа.

П.Наранбаяр: Баярлалаа. Ер нь байгаль орчны чиглэлээр яг цэвэр ийм үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг бид дэмжинэ. Бодлогоор дэмжих ёстой. Хамтын ажиллагааг нь үргэлжлүүлэх ёстой. Энэ дээр ямар ч шашны үйл ажиллагаа байхгүй. Бүгд л ойлгож байгаа шүү дээ. Яах вэ, ганц нэг ийм нэршилтэй нь холбож түрүүнд манай нэг гишүүн ярих шиг боллоо. Нэрийн орчуулга ч гэсэндээ ер нь ингээд тогтчихсон л байх л даа. Тэгэхдээ нарийн ярих юм бол зүгээр л Дэлхийн ногоон өсөлтийн институцийн хүрээлэн л гэсэн. Ингэж л ойлгогдохоор ийм л юм байна лээ. Зүгээр яах вэ, нэгдүгээрт.

Жил гаруйн өмнөөсөө яасан бол өнөөдөр ингэж оруулж ирж байна. Цаг хугацаа маш их алдаж оруулж ирж байна гэдгийг шүүмжилж харж байна.

Хоёрдугаарт, бид энэ дипломат яриа хэлэлцээг жоохон сул явуулсан юм байна. Анх үүсгэн байгуулагчийн гэрээний 15 дугаар зүйл дээр харахаар Сөүлд тэр төв байртай байгаа газар нь дипломат дархан эрх, тэр ямбыг олгоно гэж. Харин бусад гишүүн улс орнууд бол case-by-case.

Ер нь тохиолдол тохиолдлоороо тухайн улс оронтой тухайн тухайн үед нь гэрээ байгуулаад may enjoy, may seek гэдэг англи үг хэрэглэсэн байгаа юм. Тэр лүү эдэлж болно оо л гэсэн үг. Эрэлхийлнэ ээ л гэсэн үг. Ийм заалттай байсаар байтал 9 жил яахаараа дипломат дархан эрх, энэ ямбыг шаардсан юман дээр Монгол Улсын юунд нь орсон юм бэ. Айлын талын дэвжээн рүү ороод тоглогчихсон юм бэ гэдэг л асуудал байхгүй юу.

Ингээд байж байхад үгүй ээ энэ чинь ийм байна. Тэгвэл ингэж ингэж хийе ээ ч гэдэг юм уу, ийм хэлцэл хийсэн, хэлэлцээ хийсэн шинж тэмдэг ерөөсөө ажиглагдахгүй. 9 жилийн өмнөөс л манайх хүсэлт тавиад л бид ер нь хүсэлтийг нь 100 хувь хүлээж аваад л ер нь Их Хурал руу ороод л мөргөөд л буцаад байсан, мөргөөд л буцаад байсан. Одоо ч гэсэн ингэх гээд байна гэсэн ийм байдлаар асуудалд хандмааргүй байна. Гадаад харилцааны яамны чадвартай л улсууд байна. Байгаль орчны яам ч гэсэн. Ер нь байгаль орчны гадаад бодлогын чиглэлээр мэргэшсэн хүн байж байна шүү дээ. Д.Одхүү гуай гээд.

Тэгээд энэ улсууд маань яг энэ дээрээ тайлбараа их сайхан оруулж бичиж ингэсэн юм аа, тэгтэл ийм болсон юм аа гэдгээ бас манай Байнгын хороонд урьдчилж сайн өгвөл манай энэ Байнгын хороо чинь яг энэ чиглэлээрээ мэргэшсэн хүмүүс зөндөө байдаг. Бас их сэтгэлтэй ийм хүмүүс шүү дээ.

Тэгэхээр энэ бол нэг ийм юм ажиглагдаад байна. Тэгээд өнөөдөр яг энэ гэрээ хэлэлцээр маань ер нь жоохон түүхийдүү ороод ирэв үү гэсэн ийм л юутай байна. Одоо ингээд яг Intergovernmental Organization буюу Засгийн газар хоорондын байгууллага гэдгийг ойлголоо.

Монгол Улсаас ямар нэгэн төлбөр мөнгө авахгүйгээр 11 сая долларын хэмжээтэй энэ 10-аад жилийн хугацаанд ямар ч байсан зөвлөх үйлчилгээ үзүүлээд 140-өөд сая долларын хөрөнгө оруулалтыг татахад ихээхэн хувь нэмэр оруулсан гэдгийг ойлгож байна. Асуудал нь өөрөө уур амьсгалын чиглэл. Энэ өөрөө өөрөө хэрэгтэйг ойлгож байна.

Тэгээд ийм үед ингэж оруулж ирчхээд одоо ингэхгүй л бол болохгүй гээд ингээд энэ Байнгын хороог ийм нуман тулгуурт оруулах ийм байдлаар асуудалд хандахгүй байхыг л хүсэж байна.

Цаад асуудлыг нь ойлгож дэмжмээр байдаг. Гэвч ийм нөхцөл байдалд ороод ирэхээр хэцүүхэн л санагдаж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Б.Батбаатар гишүүн үг хэлнэ.

Б.Батбаатар: Одоо санал хураахад их хүнд болж байгаа. Энд байгаа бүх гишүүн нэг ч хүн татгалзахгүй санал өгч байж Байнгын хороогоор энэ дэмжигдэх гэж байна. 9 гишүүн сууж байна. Есүүлээ дэмжиж байж энэ санал дэмжигдэнэ.

Тэгэхээр би гишүүдээсээ гуйх, санал болгохыг хүсэж байгаа зүйл юу вэ гэхээр дэлхийд өнөөдөр эдийн засаг, геополитик, улс төрийн нөхцөл байдал их өөр байгаа нөхцөлд хамгийн энгийн буюу Улаан загалмайн яригддаг, мөн чадвартай адилхан хамгийн энгийн, бид нарын тоглож болох, бас улс орны хувьд, олон улсын хувьд нэр хүндээ өсгөж болох, хөрөнгө оруулалт татаж болох, хамтын ажиллагааг бий болгож чадах, дэлхийд гарах нэг гарц бол ногоон гарц юм.

Монгол руу орж ирдэг ногоон гарц Монголоос гарах ногоон гарц. Энэ гүүрийг бид барихад өөрсдөө тус нэмэр болох ёстой.

Олон жилийн өмнө хүмүүс янз бүрээр ойлгож ярьдаг. Сингапурыг бараг анхны дэмжсэн хоёр дахь нь ч билүү улс нь Монгол Улс болоод. Түүгээрээ өнөөдөр хүртэл Сингапур Монголд виз болоод бусад олон асуудал дээр бусад улсаас илүү. Ил гаргаж зарладаггүй байх л даа. Тэгэхдээ бусад улсаас илүү ханддаг гээд л ярьж байдаг. Бусад улс орон дээр ч гэсэн иймэрхүү зүйлүүд яригддаг шүү дээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн болох гэж бид арван хэдэн жил санал хураалт руу орох гэж явсан.

Тэгэхээр дэлхий өөрөө одоо энэ ногоон хандлага, ногоон суурин дээр ногоон үзэл баримтлал гэдэг чинь өөрөө баруун, зүүнтийн үзэл биш болсон. Төв үзэл болсон. Ганцхан дэлхий байгаа. Коммунист байна уу, социалист байна уу, либерал байна уу, консерватив байна уу, хаант засагтай байна уу тэрнээс үл хамаараад энэ ногооныг ярьдаггүй зүйл гэж, дэлхий дээр –

- ярьдаггүй Засгийн газар,
- ярьдаггүй улс төрийн нам,
- ярьдаггүй иргэн, аж ахуйн нэгж, олон улсын байгууллага байхгүй болсон.

Тэгэхээр энэ хандлага өөрчлөгдөж байгаа явж байгаа энэ зам дээр бид урагшаагаа түрүүлж эхний эгнээнд нь хамт алхаж байх ёстой. Монгол Улс.

Тэгэхгүй нэг байгууллагын нэр ус юм уу, нэг хүний дипломат эрх, ямбаас болоод Монгол Улсын үндэсний аюулгүй байдал сүйрчихнэ гэдэг утгаар юм яриад сууж байж болохгүй.

Харин дэлхий дээр коммунист нам, консерватив нам, ардчилсан нам, демократ нам хоорондоо өөд өөдөөсөө хараад ямар ч маргаангүй ярилцаж болдог зүйл бол дэлхийн байгаль орчин.

Ямар эзэнтэй, ямар үзэл баримтлалтай, ямар засаглалтай, ямар байхаас үл хамаараад хоорондоо дайжиж байсан ч ярьж болдог зүйл бол энэ мөн. Хоорондоо муу асуудалтай улс орнууд эдийн засгаа ярьдаггүй, бусад олон зүйлээ ярьдаггүй, харин байгаль орчин дээр ярьж байдаг. Хүмүүнлэг, эрүүл мэнд чиглэлд ярьж байдаг.

Тийм болохоор Монгол Улс урагшаагаа эхний эгнээнд дэлхийн тоглогч байхад өөрийн үүрэг ролио энэ Төв Азид, Ази Номхон далайн бүс улсад. Дээрээс нь өнөөдөр дэлхийн 197 улсын Засгийн газрын хамтран байгуулсан COP17-г зохион байгуулагч орны хувьд, цөөхөн хүнтэй ч Монгол Улсын хуурай газар нутгийн 1.1 хувийн газар нутгийг эзэлдэг ийм өргөн уудам газар нутагтай улс орны хувьд цөлжил 2020 оны 6 жилийн өмнөхөөр бол далан хэдэн хувь байгаа шүү дээ. 77 хувь. Одоогийн тооллогоор бараг наян хэд болох байх.

Тэгэхээр ийм улс орны хувьд ийм зүйл дээр нэг дипломат эрх, ямбаас болоод асуудал үүсэж өгөхгүй байх. Энд сууж байгаа 9 гишүүн есүүлээ санал өгч дэмжиж өгөөч ээ гэж ингэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Санал хураалт. Гишүүдийг Байнгын хорооны танхимд дуудаарай.

Гишүүдийг ирэх хүртэл би гишүүддээ, асуудал оруулж байгаа сайд Ц.Сандаг-Очир сайд, гишүүддээ нэг саналаа хэлээдэхье. Гишүүнийхээ хувиар.

Ийм зүйл байгаа шүү. Ц.Сандаг-Очир сайд аа. Гишүүдэд үл ойлголцол төрүүлээд байгаа энэ асуудлууд өөрөө нэг талдаа Засгийн газар хариуцлагагүй байгаа зүйл байгаа шүү.

Энэ асуудал өнгөрсөн жил орж ирсэн. Өмнөх яагаад олон жилийн хугацаанд гацсан барьсан гээд энэ асуудлууд дээр холбогдох яамдаас нь саналыг авсан.

Бид ямар нэг байдлаар энэ хэлэлцээрийг зарчмын хувьд дэмжихгүй байгаа зүйл байхгүй байгаа шүү. Бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Байгаль орчны чиглэлээр, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр Монгол Улсын Засгийн газартай, тэр дундаа танай яамтай хамтарч хийж байгаа бүгдийг дэмжиж байгаа.

Энд сая гишүүдийн хэлж байгаа асуудал нэгдүгээрт Гадаадын харилцааны яамнаас, Засгийн газраас асуугаад байгаа асуудал нь хэлэлцээрийг бид дэмжиж байна. Энэ дархан эрх, ямба гэдэг юм уу, энэ асуудлыг эргэж харах ёстой юм биш үү. Энэ чинь тухайн улсын захиргааны болоод шүүхийн гүйцэтгэх эрх мэдлээс үл хамаарах ийм зүйл болж байгаа шүү дээ. Бусад ижил төстэй байгууллагууд чинь ийм дипломат статус эдэлдэг юм уу, үүнийг зөвшөөрөх нь зөв юу юм уу, шаардлагатай юм уу л гэдэг асуудлыг нэгдүгээрт асуугаад байгаа юм.

Хоёрт, сая тэр байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нарийн ширийн мэдээлэл байхгүй учраас тодруулж асуугаад байгаа зүйл байна.

- Хөрөнгө оруулалт нь ямар юм,
- санхүүжилт нь ямар юм,
- бүтэц нь юу юм гэдэг асуудлыг л асууж байгаа.

Тэгээд бид энэ асуудлыг яг холбогдох яамдаас тодруулга авах гээд үндсэндээ сая сүүлийн хэдэн сарын хугацаанд хандахаар яг мэдээлэл өгөхгүй, хариуцлагагүй хандаж байгаа зүйл байна.

Би Гадаад харилцааны яаман дээр л хандаж хэлээд байгаа юм л даа. Та хэд сайд чинь байхгүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам өгсөн хариу дээрээ ингэж байгаа. Энэ асуудлыг Засгийн газрын тухай хуулиараа олон улсын байгууллагатай хийх гэрээ хэлэлцээрийг Гадаад харилцааны яам хариуцна. Хяналт тавих бүрэн эрхтэй.

Дээрээс нь дипломат төлөөлөгчийн газруудын эрх, ямба, халдашгүй дархан эрхтэй холбогдсон асуудлыг зохицуулах чиг үүрэг гэж байгаа шүү. Алинд нь олгох юм уу, олгохгүй юм уу. Тийм ээ. Засгийн газрын хуралдаанаар хуралдаанаар оруулах уу, оруулахгүй уу гэдэг асуудлыг чиг үүрэг зохицуулах үүрэг нь байгаад байгаа юм.

Түүнээс энд нэг байгууллага нь буруу, зөрүү юм оруулж ирчхээд л нөгөөдхөө зүтгүүлээд байгаа юм шиг би тийм юм байхгүй байх гэж хараад байгаа юм. Энэ дээр Та бүхэн зохицуулалтуудыг хийгээд хариуцлагатай хандах зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Бид Та бүхэн рүү уг нь энэ асуудлаар чинь тодорхой мэдээлэл авъя гэж хандсан. Гадаад харилцааны яам руу. Тэгээд бид бүхэнд хоёр долоо хоногийн дараа өгсөн хариу дээр бид асуусан зүйл нь ингэсэн юм. Яг энэ байгууллагын эрх зүйн байдлыг олон улсын эрх зүйн хүрээнд тодорхой тайлбарлаач чээ. Түүний үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлээч.

Хоёрдугаарт нь, хэлэлцээрийг байгуулснаар үүсэх эрсдэл, давуу талын талаарх дүн шинжилгээг явуулаач ээ гэсэн юм. Гадаад харилцааны яам руу.

Гуравдугаарт, дархан эрх, ямба эдлэх эрх бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллага гэдэг юм уу, эсвэл дипломат төлөөлөгчийн газрын албан тушаалтан ажилтнаас бусад этгээдэд тусгайлан дархан эрх, ямба эдлүүлэх эсэх асуудлаар гэдэг асуудлыг тавьсан. Та бүхэн түүн дээр бусад Олон Улсын Валютын Сан, бусад Азийн хөгжлийн банк ч гэдэг юм уу, ийм ийм яаж байна, тодорхой хариулт ирүүлэх ёстой байсан.

Тэгээд дээрээс нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох конвенц, дипломат харилцааны тухай, консулын харилцааны тухай, Венийн конвенцод заасан дархан эрх, ямба эдлэх эсэх асуудал эсэх талаарх мэдээллийг ирүүлнэ үү л гэсэн ийм зүйлийг өгсөн юм.

Тэгээд Та бүхэн хариулт нэг ийм бөөрөнхийрсөн. Энэ саналыг Байгаль орчны яам гаргасан тул тэндээс мэдээлэл ав гэж байгаа юм. Бид уг нь манайд Та бүхэн тайлагнах үүрэгтэй. Манай Байнгын хороонд хамаарах тусгай чиг үүрэг бүхий яам.

Тэгээд эргүүлээд яг саяын тэр Нэгдсэн Үндэстний Байгууллага болоод бусад байгууллагуудын эрх эдлүүлэх юм уу гэсэн асуудал дээр болохоор энэ байгууллага нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд хамаарахгүй болно гээд ингээд хариулчхаж байгаа юм.

Тэгэхээр Та бүхэн яг үндсэндээ чиг үүргээ нэгдүгээрт хэрэгжүүлэхгүй байна шүү. Хуулиар олгогдсон эрхүүд дээр аягүй хариуцлагагүй хандаж байна.

Ингээд ийм хариуцлагатай асуудлууд дээр ийм дипломат байдлаар бөөрөнхийлөөд хариулт өгөхгүйгээр ингэж байдаг нь эргээгээд гишүүдийг ийм юунд оруулж байгаа юм.

Би ний нуугүй хэлье. Одоо зарчмын тулд бид үйл ажиллагааг нь ямар нэг байдлаар хийж байгаа юм байхгүй шүү. Тийм ээ. Энд яаж байна гэхээр Хууль зүй, дотоод хэргийн яам өгсөн бичиг харьяан дээрээ энэ дипломат ямба, дархан эрх эдлэх тусгайлан эдлүүлэх эсэх асуудлыг дахин нягтлах шаардлагатай гэсэн бичгийг Хууль зүйн сайд нь ирүүлсэн байгаа.

Сангийн сайд хөрөнгө оруулалт татдаг төрлийн ашгийн төлөө бус сан хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагад Монгол Улс эрх, ямба, дархан эрх олгож, татвараас чөлөөлж байгааг анхаарах хэрэгтэй гэсэн.

Тэгээд гэрээний хэлцэл, хэлэлцээрүүдийн тодорхой заалтуудыг хасах саналтай байсан гэсэн ийм саналыг өгсөн байгаа юм.

Тэгэхээр бид одоо Байнгын хороо санал хураагаад дэмжсэн тохиолдолд саяын яамдаас ирсэн саналуудыг бид протоколд тусгуулаад Та бүхэн зөвшилцөх эсэх хэлэлцээр хийгээд зурахдаа эдгээр асуудлуудыг хасаад гэдэг юм уу. Тийм ээ. Ингээд үндсэн хэлэлцээрээ батлаад явах ийм эрхтэй байхаар ингэж хийж байгаа шүү. Энэ бол үндсэндээ Засгийн газарт Та бүхэнд нэг дээвэр доор, нэг Засгийн газрын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа кабинетын яамд чинь ийм байр суурьтай байна. Үүнийг нэгтгэж зохицуулах үндсэн чиг үүрэг Гадаад харилцааны яаман дээр байгаа. Та бүхэн зохицуулалтуудыг эхнээсээ базаад зангидаад ингээгүй олон жилийн хугацаанд ужгируулсан ийм асуудлууд байх шиг байна. Энэ талаас болоод ч гэсэн хардаж сэрдэж байгаа тийм асуудлууд байх шиг байна шүү.

Тэгэхээр үүнийг үйл ажиллагаандаа анхаараарай. Сайд нартаа хэлээрэй. Ж.Соёлмаа захирал. Тийм ээ.

Д.Цогтбаатар гишүүн үг хэлье.

Д.Цогтбаатар: Гишүүд ээ, энэ дээр би Та нараас нэг юм хүсье.

Ийм асуудал дээр аймаар том асуудал болно. Энэ чинь аягүй жижигхэн асуудал байхгүй юу. Энэ дипломат юманд.

Одоо Вена, Женев гэдэг чинь хэн орж ирсэн байгууллагууд нь бид энэ боломжийг нь өгнө гэж байж дэлхийн төв, бодлогын төв болж байгаа байхгүй юу.

Бид иймхэн юм. Одоо үүний ард юу байдаг гээч. Нэг ийм оффис байгуулаад, гаднаас нэг жийп, даргынхаа жийп, нэг диван оруулж ирэхэд нь гаалийн татварын асуудал байхгүй юу. Түүнээс энэ дээр аймаар том юм ерөөсөө байхгүй.

Би Гадаад яаман дээр IDLO² (International Development Law Organization)-гийнхон орж ирэхэд аймаар том бюрократууд ингээд суучихсан. Венийн конвенц ярихаар мэддэг амьтан байхгүй.

Тэгээд би үгүй ээ, үгүй наадхыгаа олго. Яагаад гэвэл үүгээр чинь аягүй их тусламж, дэмжлэг орж ирдэг гээд.

Тэгээд үүгээр нээрээ IDLO-гоор Монголд эрх зүйн чиглэлийн аягүй олон саналууд орж ирсэн. Дэмжлэгүүд орж ирж байгаа. Ажиллаж байгаа. Та нар хүний эрх гээд л яриад л явахаар манайд тэр болгоныг мэддэггүй шүү дээ. Бүгдээрээ мэддэг юм шиг ярьдаг. Тэгэнгүүт тэр IDLO-гоос очоод асуухад харин манайд ямар их тусламж үзүүлээд дэмжихсэн байгаа.

Тэгэхээр энэ дипломат эрх, ямба гэдэг бол нэг Элчин сайдын яамны дайны юм ерөөсөө авах гээд байгаа биш. Энэ чинь олон улсын байгууллагын эрх, ямба. Аягүй жижигхэн асуудал байхгүй юу. Ардаа жоохон юм.

Хамгийн тэнэг юм нь юу болдог вэ гэхээр яг энэ байгууллагуудын хүсээд байдаг юм нь тусламжаар юм оруулаад ирэхээр гаалиас ёстой татвар авах гээд байдаг байхгүй юу. Тэд нарт тэр гаалийн татварыг нь өгдөг төсөв байхгүй. Тусламжийн байгууллага юм чинь.

Тэгэхээр энэ юман дээр. Ялангуяа одоо энэ GGGI гээд Бан Ги Мүн гуайн байгууллага. Мөн биз дээ. Миний ярьж байгаа. Тийм. Бан Ги Мүн гуай гэдэг бол. Одоо би яг өөрөө хоёр дахиа сонгогдоход нь эндээс та нар бод доо. “LDC³ тинк танк” гэдгийг бид байгуулаад. Одоо би болж байсан юм.

Дипломат юун дээр яаж хэрэг болдог вэ. Улаанбаатарт хурал хийлээ. Тэгсэн чинь Бан Ги Мүн гуай нэрээ дэвшүүлэх үү, үгүй юу гээд хүмүүс янз бүрийн юм яриад байхад нь би энд Улаанбаатарт декларацад нь Бан Ги Мүн гуай сайн ажилласан. Бид дэмжээд өгье гээд. Тэр тинк танкийг нь байгуулах гэж мянган юм болж, бас л олон улсын байгууллага энд тэнд юм яриад байдаг байсан.

Тэгсэн бид түүгээр байгуулаад Бан Ги Мүн гуайд өөрөө гуйгаагүй байхад нь нэг параграф оруулаад энэ хүнийг дэмжээд Ерөнхий нарийн бичгийн дарга болгохыг дэмжиж байна гээд 32 орны тогтоол гарч байгаа байхгүй.

Дараа нь би тэрийг Нью-Йоркт очоод н.Энхцэцэг даргатай уулзаж байгаад би Бан Ги Мүн гуайгаас цаг авъя гэж гүйхгүй ээ. Элчин сайдыг нь дуудаад ир гээд. Элчин сайд нь сэтгэлээсээ би таныг хоёр дахиа сонгогдох 32 орны саналыг жижиг Монгол Улаанбаатарын тунхаглалаар аваад ирлээ гээд өгөөд л яваад өгч байгаа юм. Тэрийг Бан Ги Мүн гуай.

² IDLO нь хөгжиж буй болон шилжилтийн үеийн улс орнуудад хууль, эрх зүйн тогтолцоог сайжруулах, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэхэд тусалдаг **intergovernmental organization** гэсэн статустай олон улсын байгууллага.

³ **Least Developed Countries (LDC)** -нь эдийн засаг, хүний хөгжлийн үзүүлэлт сул, бүтцийн эмзэг байдал өндөр, хөгжлийн тусгай дэмжлэг шаардлагатай гэж НҮБ-аас ангилсан дэлхийн хамгийн эмзэг хөгжиж буй орнуудын бүлэг.

Тэгээд өнөөдөр болтол бид нартай яг хувь хүний хувьд Монголчууд ингээд сэтгэлээсээ дэмждэг юм гээд яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр хэдүүлээ нэг ийм. Тэгээд ногоон хөгжил, тэгээд **Green Diplomacy** гэдэг. Дэлхийн хамгийн том **New Diplomacy** болчихоод байгаа байхгүй юу.

Тэгээд үүнийг нь хэдүүлээ дэмжээд өгөхөд Монголоос юу ч унахгүй. Эд нар бид нараас юу ч хожиж авахгүй. Харин зөндөө юм татаж оруулж ирнэ.

Г.Тэмүүлэн: Би дахиад яг эцэст нь санал хураалтын өмнө хэлэх гэж байгаа юм шүү.

Хэрэв дэмжигдээд явлаа гэхэд Засгийн газар доторх байр сууриуд чинь өөрсдөө нэгдмэл биш байна. Та бүхэн Засгийн газар цаашаа хэлэлцээрийг зөвшилцөх эсэх асуудал дээрээ гарын үсэг зурахдаа яамдынхаа саналыг аваач ээ. Тэр дундаа Засгийн газрын тухай хуулиараа.

Мөн дээрээс нь танай яамны чинь яг хөтөлбөрийнхөө дагуу Гадаад харилцааны яам бол энэ дээр үндсэндээ олон улсын байгууллагатай хийх гэрээ хэлэлцээр дээр өөрсдөө онцгойлон анхаарах үүрэгтэй байна. Хяналт тавих үүрэгтэй байна.

Дээрээс нь яг энэ дархан эрх, ямба болоод халдашгүй эрхтэй холбоотой асуудлуудыг зохицуулах чиг үүргийг Та бүхэн хийх ёстой байгаа юм.

Тэгэхээр өнөөдрийн үүсэж байгаа асуудал чинь юу вэ гэхээр нэгд зохицуулалт хийгээгүй байна. Сангийн яам чинь өөрөө дархан эрх, ямба эдлүүлээд байх шаардлагагүй, хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлээд байх шаардлагагүй гэсэн бичиг өгсөн байна.

Мөн дээрээс нь Хууль зүйн сайд нь энэ асуудлыг эргэж харах ёстой гэсэн саналыг өгсөн байна.

Та бүхэн ингээд саналаа өгөхдөө Гадаад харилцааны яамнаас гэрээ хэлэлцээрийнхээ төслийнхөө бүр зүйл, заалттайгаар үүнийг өөрчилье, үүнийг хасъя гэсэн саналуудыг өгсөн байгаа байхгүй юу.

Тэгэхээр Ж.Соёлмаа дарга аа, би танд хариуцлагатайгээр хэлж байгаа зүйл нь Та яамны Гэрээ, эрх зүйн газрын даргын хувьд яг энэ хэлэлцээрийг өөрөө гардаад хийгээд гарын үсэг зуруулаад эцэслээд дуусгаарай. Тийм ээ. Та өөрөө энэ өгсөн. Таны өгсөн. Мэдэхгүй. Ямар ч байна. Яамнаас ирүүлсэн бичиг дээр ийм санал байгаа юм. Би уншъя.

Гадаад харилцааны яамнаас ирсэн санал шүү. Би бүх яамдын саналыг протоколд тусгаад хэлэх гээд байгаа юм.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу соёрхон батлах олон улсын гэрээ нь гарын үсэг зурснаар шууд хүчин төгөлдөр болох боломжгүй. Иймд 15 дугаар зүйлд заасан “гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно” гэдгийг “энэхүү хэлэлцээрийг соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг солилцсон өдрөөс хүчин төгөлдөр болно” гэж өөрчлөх гэсэн санал байна.

Ингээд энэ танай яамны санал байх нь байна. Хэлэлцээрийн төслийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг Засгийн газар нь дотоодын хууль тогтоомжийн хүрээнд ямарваа нэг төлбөр хураамж авахгүйгээр төлөөлөгчийн газарт томилогдон ажиллах зорилгоор Монгол Улсад оршин суухаар ирсэн дараах хүмүүст Монгол Улсад орох, гарах, чөлөөтэй зорчиход шаардлагатай бүх арга хэмжээг авахыг эрмэлзэнэ гэж өөрчилж, мөн зүйлийн 2 дахь хэсгийг бүхэлд нь хасах гэсэн санал байна шүү.

Тэгээд гуравт нь ингэсэн байгаа юм. Даян дэлхийн ногоон хөгжлийн институцийн албан тушаалтан, тэдгээрийн гэр бүлийг бүх төрлийн татвар, хураамжаас чөлөөлөхтэй холбоотой бүхий л заалтуудад Сангийн яамны саналыг тусгах зэрэг болно гэсэн байгаа шүү.

Тэгэхээр энэ бол танай Гадаад харилцааны яамны байр суурь. Та бүхэн эхлээд өөрсдийнх нь санал байх нь байна. Гуравдугаарх нь, Сангийн яамны саналыг харгалзаж үзээрэй гэсэн ийм санал өгсөн байгаа юм.

Тэгэхээр Та бүхэн маань одоо бол мэдээж энэ одоог хүртэлх явц, одоо энэ хэлэлцээрийн төсөл дээрээ Ц.Сандаг-Очир сайд аа, Ж.Соёлмаа даргыг оролцуулаад ингээд үг үсэг, найруулгуудыг нь янзлаад явах нь байна.

Сангийн сайд ийм бичиг ирүүлсэн байгаа. Би эдгээрийг бүгдийг нь хавсралтаар явуулна. Сангийн сайдын 2026 оны 6 сарын 08-нд ирүүлсэн зүйл дээр ингээд хөрөнгө оруулалт татдаг төрлийн ашгийн төлөө бус. Энэ ямар ч бай дархан эрх, ямбатай холбоотой татвараас хөнгөлж чөлөөлж байгааг анхаарах хэрэгтэй гэсэн байгаа юм. Саналыг нь албан ёсоор та хэд эцэслээдэх яг ямар асуудлаар яах юм.

Дээрээс нь энэ төслийн 4 дүгээр зүйл болон 9 дүгээр зүйлийн 9^б, 9^в, 9^ж дэх хэсгүүдийг хасах саналтай байна гэсэн саналыг Сангийн сайд ирүүлсэн байгаа.

Тэгээд үүнээс гадна Монгол Улсын Засгийн газраас гадаад улсын Засгийн газар, олон улсын байгуулалттай байгуулсан хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн гэрээний дагуу авсан барааг.

Ингээд ингэж байна шүү. Тухайн зээл, тусламжийг олгох талаарх байгуулах гэрээ хэлэлцээрт тухай бүрд тусгах, эсвэл одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хууль тогтоомжийг нь чөлөөлөх байдлаар зохицуулах боломжтой гэсэн саналыг өгсөн байгаа шүү.

Тэгэхээр Та бүхэн Сангийн яамныхаа энэ асуудлуудыг нягтлаарай. Ерөнхийдөө ийм саналууд байна шүү.

Тэгэхээр би энэ асуудлуудыг протоколд тусгаж байна шүү. Бид нар, Их хурал, Байнгын хороо энэ асуудлуудыг гацаагаад байсан зүйлүүд байхгүй. Эхлээд байр суурийг чинь нэгтгэх гэж хараад байгаа юм. Засгийн газрын.

Үүнийг үндсэн чиг үүрэг зохицуулах үндсэн бүрэн эрх, чиг үүрэг, харилцаа нь хуулиараа танайд олгочихсон байгаад байгаа учраас дараа дараагийн гэрээ, хэлэлцээрүүд дээр ийм зүйлийг алдаатай оноотой, байр суурь нь тодорхойгүй, нэгдмэл бус, үл ойлголцол үүсгэсэн зүйлийг Засгийн газраас бий болгож болохгүй.

Яг өнөөдрийн байгаа Засгийн газрын байр суурь, байгаа байдал чинь ерөөсөө яг ийм байгаад байна шүү дээ. Тийм ээ. Үндсэн тусгай чи одоо юу гэдэг юм үндсэн чиг үүргийн яамдууд нь Хууль зүйн яам нь, Сангийн яам нь, Гадаад харилцааны харилцааны яамны яам юмнууд энэ дээрээ байр сууриа тодорхой гаргаж өгөхгүй үл ойлголцолтой байгаад байгаа юм.

Тэгэхээр би үүнийг онцгой анхааруулж үзэж байгаа шүү.

Ингээд та өөрөө толгойгоороо хариуцаад энэ хэлэлцээрийг дуусгаад, эцэслэн батлаад, эргээд соёрхон батлахаар орж ирэхэд энэ асуудлууд бүрэн дүүрэн шигтгэгдээд шийдэгдсэн, ямар нэг үл ойлголцолгүй, бүх бүрэн дүүрэн мэдээллүүдийг наашаа өгсөн байх ёстой гэдэг анхааруулгыг өгч байна шүү. Гадаад харилцаанд.

Одоо ингээд саналаа хураая. Тэгэх үү? Тэгээд гишүүд ямар байсан ч өөрсдийнхөө итгэл үнэмшлээрээ, саналаараа саналаа өгнө.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан, үг хэлж дууссан. /алх цохив/

Санал хураалтад бэлтгэе. 13 гишүүн бэлэн байна уу?

Санал хураалтыг явуулж эхэлье. Манайхан 11. Би томьёоллыг нь уншаадахъя.

Даян дэлхийн ногоон хөгжил институцийн эрх зүйн байдал болон эрх, ямба дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжил институц хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ. /алх цохив/

Ингээд саяын протоколд тусгасан, хэлсэн саналуудыг Засгийн газар анхаарч ажиллах хэрэгтэй байна. Соёрхон батлахдаа Байнгын хороо, Улсын Их Хурлаар орно гэдгийг онцгойлон хэлэх байна шүү.

Ингээд Засгийн газарт саяын тэмдэглэл, санал, дүгнэлтүүдийг хүргүүлнэ.

Энэ хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

Өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан байна. Ингээд хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

Хуралдаан 1 цаг 53 минут үргэлжилж, 13 цаг 08 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД